

**НИЙГМИЙН
ТУХАЙ МЭДЛЭГ**

2007

ХУВИЛБАР А

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Ангийн чинь нэг сурагч чамд хоч өгөх нь ямар дургүйцэл санц вэ? (2 оноо)
А. Албан ёсны
В. Албан ёсны бус
С. А, В хоёулаа
D. Хоч авагч өөрөө буруутай тул асуулт оновчгүй
E. Эдгээрээс өөр
2. Нийгмийг зөвхөн нийгмийн хүчин зүйлсээр тайлбарлах бөгөөд нийгмийн үйл явцад байгалийн хүчин зүйлс бараг үүрэггүй гэж үздэг онол байдаг. Энэ онолын төлөөлөгчдөөс В.Парето, Г.Моска нар доорх өгөгдлийн аль үзлийг баримтлагчид вэ? (3 оноо)
А. Сэтгэл зүйн сургаалтнууд
В. Элитийн онол
С. Эдийн засгийн онол
D. Бүтэц, үүргийн онол
E. Иргэншлийн онол
3. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол "... гэдэг нь нийгэм ба соёлоос хожуу үүссэн ч дэлхийчлэлийн цар хүрээний ач холбогдолтой, нийгэм ба нийгэмлэгүүдийн соёлын хөгжлийн шат түвшин болон тэдгээрийн өвөрмөц шинжийг тусгасан ойлголт" юм. (2 оноо)
А. Даяаршил
В. Нийгэмшил
С. Иргэншил
D. Уламжлал
E. Эдгээрээс өөр
4. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. ... институт нь нэг үеэс дараагийн үед тухайн нийгэмд дээдлэгдэгч соёлыг уламжлуулан залгамжлуулах хойч үеийг бэлтгэх чиг үүрэгтэй. (2 оноо)
А. Улс төр
В. Шашин
С. Боловсрол
D. Гэр бүл
E. Эдийн засаг
5. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. Нийгмийн өсөн нэмэгдэж буй ээдрээтэй байдлын шалтгаан, үр дагавар ... юм. (2 оноо)
А. Нийгмийн өөрчлөлт
В. Нийгмийн хувьсал
С. Хөдөлмөрийн хуваарь
D. Нийгмийн дэвшил
E. Эдгээрээс өөр
6. Нийгмийн бүрдэл хэсгүүдийн хоорондын байнгын тогтвортой, эмхлэгдсэн, журамлагдсан, харилцаа холбооны цогц байдлыг тусгах ойлголт доорх өгөгдлөөс аль нь вэ? (2 оноо)
А. Нийгмийн байдал
В. Нийгмийн бүтэц
С. Нийгмийн үйлчлэл
D. Нийгмийн үүрэг
E. Аль нь биш
7. Нэгдэл холбоо нь өөрийн өмч болох нутаг дэвсгэртэй, уг нутаг дэвсгэр нь өөрийн нэр, өөрийн түүхтэй гэж хэн үздэг вэ? (2 оноо)
А. Э.Шилз
В. Р. Мертон
С. Платон
D. Р. Марш
E. Аристотель
8. Анх социологи хэмээх нэр томъёог хэрэглэн, нийгмийг шинжлэх ухааны үүднээс судлах зорилгыг хэн дэвшүүлсэн бэ? (2 оноо)
А. Ж.Руссо
В. О.Конт
С. Платон
D. Т.Гоббс
E. Ж.Локк
9. Аж үйлдвэржсэн нийгмийн үйлдвэрлэлд юу давамгайлдаг вэ? (2 оноо)
А. Хөдөө аж ахуй
В. Аж үйлдвэр
С. Үйлчилгээний хүрээ
D. Мэдээллийн технологи
E. Эдгээрээс өөр
10. Нуклеар гэр бүл баяртай гэж, өндөр хөгжилтэй орнуудад бичих болсон ажээ. Үүнийг юу гэж ойлгох вэ? (2 оноо)
А. Ганц бие хүмүүсийн тооны өсөлт
В. Ижил хүйстнүүдийн гэрлэлт
С. Эхнэр, нөхөр бүтцийн өсөлт
D. Нөхөр, эхнэр, хүүхэд бүтцийн бууралт
E. Аль нь биш
11. УИХ ээлжит чуулганаараа бүрэн эрхийнхээ хүрээнд "Татварын багц хууль"-иудын төслийг хэлэлцсэний үр дүнд хувь хүний орлогын болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг өмнөх хуулинд заасан хэмжээнээс бууруулах шийдвэр гаргажээ. Энэ нь улс төрийн системийн ... юм. (2 оноо)
А. Орлолт
В. Гаралт
С. Дэмжлэг
D. Шаардлага
E. Эргэх холбоо
12. Төрийн улс төрийн бусад байгууллагаас ялгагдах гол онцлог шинж нь: (2 оноо)
А. Хамтын шийдвэр гаргадаг
В. Удирдагчтай
С. Гишүүнчлэлтэй
D. Албадлага хэрэглэдэг
E. Ялгаа байхгүй

13. Төр үүсэхэд нөлөөлсөн дараах хүчин зүйлсүүдээс илүүц нь аль вэ? (2 оноо)
 - A. Хүмүүс үйлдвэрлэл явуулж, хэрэгцээгээ хангах орон зайтай байх үүднээс газар нутгаар зааглагдсан явдал
 - B. Нийгмийн томоохон бүлгүүдийн хэрэгцээ сонирхолд гол гол ялгаа бий болж, тэдгээрийн харилцааг зохицуулах үүднээс
 - C. Хүмүүс газар нутгаа бусдаас хамгаалах үүднээс
 - D. Нийгмийн тогтвортой байдлыг хангах үүднээс
 - E. Байгалийн объектив зүй тогтол
14. АНУ-ын анхны сонгуульд нийт насанд хүрэгчдийн 23% сонгуулийн эрхтэй байсан бөгөөд 1920 онд эмэгтэйчүүдийн, 1965 онд хар арьстаны, 1971 онд 18-20 насны залуусын сонгуулийн эрхийг хүлээн зөвшөөрчээ. Өгөгдөлтэй тохирох бодомж аль нь вэ? (3 оноо)
 - A. Цөөнхийн тэгш бус эрхээс бүх нийтийн тэгш эрх болон өргөжсөн
 - B. Цөөнхийн тэгш эрхээс бүх нийтийн тэгш эрх болон өргөжсөн
 - C. Бүх нийтийн тэгш бус эрхээс цөөнхийн тэгш бус эрхэд шилжсэн
 - D. Бүх нийтийн тэгш эрхээс цөөнхийн тэгш бус эрхэд шилжсэн
 - E. Сонгуулийн эрхэд ямар ч өөрчлөлт гараагүй
15. М. Вебер улс төр хэмээх ойлголтыг хэрхэн тодорхойлсон бэ? (2 оноо)
 - A. Улс төр нь засгийн эрх мэдлийг ашиглан нийгмийн дотор үнэт зүйлсийг хуваарилан байршуулах үйл ажиллагаа мөн
 - B. Улс төр нь эрх мэдэлд хүрэх эрх мэдлийг тогтоон барьж байх болон ашиг хонжоо олохын тулд эрх мэдлийг ашиглах албадлагын арга хэрэгслийн цогц юм.
 - C. Улс төр нь эрх мэдэлд оролцох түүнийг хуваарилахад нөлөөлөхийн төлөө эрмэлзэн тэмцэх явдал юм
 - D. Улс төр бол өөрсдийн нийгэм эдийн засгийн өвөрмөц ашиг сонирхол болон зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дэлхийн систем ба улс гүрэн, анги, түүний намаас явуулж байгаа тэмцэл, зөрчил нэвт шингэсэн нийгмийн амьдралын нэг хүрээ юм.
 - E. Улс төр бол эрх мэдэл юм
16. Хүн амыг бүхэлд нь юм уу эсвэл нийгмийн нэг тодорхой хэсгийг төлөөлсөн бүлэг хүмүүс ба байгууллагын төрийн засаглалд нөлөөлөх, оролцох идэвхтэй үйлдлийг улс төрийн шинжлэх ухаанд юу гэх вэ? (2 оноо)
 - A. Улс төрийн шийдвэр
 - B. Улс төрийн дэглэм
 - C. Улс төрийн соёл
 - D. Улс төрийн үйл ажиллагаа
 - E. Улс төрийн бодлого
17. “Ардчилал нь олон түмэн аз жаргалынхаа төлөө тэмцэж, амь зуух эрх чөлөөгөө эдлэх найдвар мөн” гэж хэн тодорхойлсон бэ? (2 оноо)
 - A. Т.Жефферсон
 - B. А.Линкольн
 - C. Ж.Тойнби
 - D. У.Черчилль
 - E. О.Шпенглер
18. Улс төрийн намын үндсэн шалгууруудаас аль нь илүүц вэ? (2 оноо)
 - A. Оршин тогтнох цаг хугацаа буюу удаан хугацаагаар оршин тогтнох чадвартай байх
 - B. Засгийн эрхийн төлөө тэмцэх чадвартай байх
 - C. Удирдах төв ба орон нутгийн байгууллагатай байх
 - D. Олон улсын улс төрийн ямар нэгэн байгууллагад нэгдсэн байх
 - E. Тодорхой мөрийн хөтөлбөртэй байх
19. Улс төрийн мэдрэмж, ойлголт, уламжлал, үнэлэлт, дүгнэлт, үзэл санаа, улс төрийн ашиг сонирхол, итгэл үнэмшил, улс төрийн мэдлэг, онол зэргийн нийлбэр цогцыг улс төрийн шинжлэх ухаанд ... гэж үздэг. Зөв хариултыг ол. (2 оноо)
 - A. Улс төрийн шийдвэр
 - B. Улс төрийн бодлого
 - C. Улс төрийн дэглэм
 - D. Улс төрийн ухамсар
 - E. Улс төрийн үйл ажиллагаа
20. Улс төрийн засаглал хэмээх ойлголтод үл хамаарахыг ол. (2 оноо)
 - A. ИЗН-ын дарга шинэ гишүүндээ батлах олгов
 - B. Монгол Улсын ерөнхийлөгч УИХ-аас баталсан хуулинд хориг тавив
 - C. УИХ, Үйлдвэр худалдааны сайдыг томилов
 - D. МАХН-ын гишүүн, ... дугаар дунд сургуулийн захирал сургуулийнхаа дотоод журмыг батлав
 - E. Засгийн газар нэн ядуу өрхийн нэг хүүхдийг үнэ төлбөргүй сургах талаар тогтоол гаргав
21. Иргэн Готов хорих ангид ял эдэлж байсан. Тэрээр хорих ангидаа ажил хөдөлмөрт хичээнгүй, шударга шулуун, үлгэр жишээ болж хүмүүжсэн. “Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ой”- гоор тэрээр төрийн өршөөлийг үзэж хугацаанаас өмнө суллагджээ. Өршөөл үзүүлэх шийдвэрийг хэн гаргах вэ? (2 оноо)

- А. Тухайн хорих ангийн дарга
С. УИХ
Е. Улсын Дээд шүүх
- В. Хууль зүйн сайд
D. Ерөнхийлөгч
22. Эдийн засгийн шинжлэх ухааны гол үүргийг тодорхойл. (2 оноо)
А. Эдийн засгийн үйл ажиллагааг зохицуулах
В. Эдийн засгийн үйл ажиллагааг зохион байгуулах
С. Эдийн засгийн үйл ажиллагааг шийдвэрлэх
D. Эдийн засгийн үйл ажиллагааны талаар таамаглал дэвшүүлэх
Е. Эдгээрээс өөр
23. Доорх өгөгдлөөс макро эдийн засгийн судлах ойлголтыг ол. (2 оноо)
А. Хэрэглэгч ба үйлдвэрлэгчийн онол
В. Үйлдвэрлэлийн хэрэгсэл, ажиллах хүч
С. Үнэт цаас, мэдээллийн зах зээл
D. Зах зээлийн үнэ бүрдэлт
Е. Улсын мөнгөн гүйлгээнд өөрчлөлт оруулах
24. Хөдөлмөрийн зах зээл дээр ажилгүйдэл ямар үед их өсдөг вэ? (2 оноо)
А. Ажил хайгч хүмүүсийн тоо ажлын байрнаас их үед
В. Ажил хайгч хүмүүсийн тоо ажлын байрнаас бага үед
С. Ажил хайгч хүмүүсийн тоо ажилтай хүмүүсээс их
D. Ажил хайгч хүмүүсийн тоо ажилтай хүмүүсээс бага
Е. Ажил хайгч хүмүүсийн тоо ажлын байр тэнцвэртэй тохиолдолд
25. Улсын төсвийн урсгал зардлыг 3 ангилдаг. Тэгвэл Засгийн газрын бондын хүү аль зардалд орох вэ? (2 оноо)
А. Бараа үйлчилгээний зардал
В. Зээлийн үйлчилгээний зардал
С. Татаас ба урсгал шилжүүлэг
D. В ба С зөв
Е. Эдгээрээс өөр
26. Мөнгө ямар нөхцөлөөс болж үүссэн бэ? (2 оноо)
А. Барааг мөнгөөр солиход
В. Мөнгөний ханш тогтооход
С. Барааг хэмжиж тоолоход
D. Бараа солилцооны ханш тогтооход
Е. Барааг бараагаар солилцох үед
27. Төгс өрсөлдөөнт зах зээл дээр пүүсүүд үнэд яагаад нөлөөлж чаддаггүй вэ? (2 оноо)
А. Бараа үйлчилгээний үнэ хоорондоо ижил учир
В. Пүүсүүд үнэ өөрчлөвч ашиггүй тул үнэ өөрчлөх сонирхол байдаггүй
С. Пүүсүүдийн үнэд засгийн газар хяналт тавьдаг
D. Тухайн нэг пүүсийн зах зээлд эзлэх байр суурь бага
Е. Бараа үйлчилгээний үнэ хоорондоо адил биш учир
28. Иргэн Дорж ажилгүй нэгэн бөгөөд дүүргийнхээ хөдөлмөр эрхлэлтийн албанд хуулийн дагуу бүртгүүлж, зохих тэтгэмжийг авчээ. Гэвч энэ тэтгэлэг зогсов. Өгөгдлөөс тэтгэлэг зогссон шалтгаанд хамааралгүйг ол. (2 оноо)
А. Зохион байгуулалттай мэргэжлийн сургалтад суралцаагүй
В. Хорих ялын шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон
С. Хоёр удаа ажлын санал өгөхөд түүнийг авалгүй татгалзсан
D. Түр чөлөөтэй хүний оронд хүндэтгэх шалтгаангүйгээр ажиллахаас татгалзсан
Е. Эдгээрээс өөр
29. Зар сурталчилгааны явцад барааныхаа үнийг зөвхөн манай дэлгүүр ингэж буурууллаа, өөр дэлгүүрт илүү хямд байвал бид бас үнийг бууруулж чадна... гэсэн рекламьг бид олонтоо сонсож харсан билээ. Энэ нь ямар зах зээл вэ? (2 оноо)
А. Төгс өрсөлдөөнт зах зээл
В. Монополь зах зээл
С. Олигополь зах зээл
D. А ба В зөв
Е. Эдгээрээс өөр
30. Чи хурд сайтай хамгийн сүүлийн үеийн компьютер авах санхүүгийн боломжтой. Гэвч чамд чиний хүссэн компьютер олдохгүй байна. Үүнийг эдийн засгийн ухаанд юу гэж тодорхойлдог вэ? (2 оноо)
А. Эрэлт
В. Хүсэл
С. Хэрэгцээ
D. Сонирхол
Е. Хүслээ хэрэгжүүлэх бэлэн байдал
31. Ижил төрлийн, орц адил, хоол зоогийн газарт 1500 төг байхад танай сургуулийн гуанзанд 1000 төг байв. Энэ хамаарал юугаар илэрхийлэгдэх вэ? (2 оноо)
А. Эрэлтийн муруй
В. Нийлүүлэлтийн муруй
С. Чанар
D. Зоогийн газар тул 1500 төг
Е. Эдгээрээс өөр

32. Дараах эдийн засгийн ойлголтуудыг зөв холбо. (2 оноо)
- | | |
|-----------------|--|
| 1. Меркантизм | a. Хөдөлмөрийн хуваарийн нөхцөлд хүмүүс хувийн ашиг хонжоо хайж, арилжаа солилцооны явцад нийгмийн ашиг сонирхолд нийцсэн үндэсний баялгийг бүтээдэг |
| 2. Физиократизм | b. Ашиг ба хүү бол нэмүү өртөг |
| 3. Адам Смитт | c. Гадаад худалдаагаар баялаг бүтээгддэг |
| 4. Т. Мальтус | d. Чөлөөт худалдааг дэмждэг бөгөөд ХАА-н бүтээгдэхүүний хувьд хязгаарлалтгүй байх ёстой гэж үздэг |
| 5. К. Маркс | e. Нөөц хомсдож, өгөөж тогтмол буурсаар байх үзэгдлийг өгөөж буурах хууль гэнэ |
- A. 1c 2d 3e 4b 5a B. 1c 2d 3a 4e 5b C. 1d 2e 3c 4b 5a
D. 1d 2e 3a 4b 5c E. 1e 2d 3a 4c 5d
33. Дараах өгөгдлийг зөв тохируул. (2 оноо)
- | | |
|-----------------|---|
| 1. Албан татвар | a. Төрийн өмчийг ашиглуулсны төлөө иргэн аж ахуйн нэгж байгууллагаас авч улс, орон нутгийн төсөв, тусгай зориулалтын санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө |
| 2. Хураамж | b. Хариу төлбөргүйгээр улс болон орон нутгийн төсөвт оруулж буй мөнгөн хөрөнгө |
| 3. Төлбөр | c. Хууль тогтоомжийн дагуу төрийн зохих байгууллагаас иргэн аж ахуйн нэгж байгууллагад үйлчилгээ үзүүлсний төлөө тэднээс тухай бүр авч улс, орон нутгийн төсөвт оруулж буй мөнгөн хөрөнгө |
- A. 1a 2c 3b B. 1b 2d 3a C. 1c 2a 3b
D. 1b 2c 3a E. 1c 2b 3a
34. Нээлттэй нийгмийн үзэл санааг боловсруулж “... түүний дайснууд” хэмээх номыг бичсэн хүн хэн бэ? (2 оноо)
- A. Б. Рассель B. К. Поппер C. К. Маркс
D. М. Вебер E. Зөв хариулт байхгүй
35. Орчин үеийн нийгмийн давхраажилтын хэмжигдэхүүнүүдийг дурьдахдаа илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ? (2 оноо)
- A. Эд баялаг B. Эрх мэдэл C. Боловсрол
D. Угсаа гарвал E. Нэр хүнд
36. Эртний Грекийн философич Аристотель өөрийн амьдарч байсан нийгмийнхээ давхрааны хамгийн доод хэсгийнхнийг “ярьдаг зэвсэг” гэж нэрлэж байжээ. Тэгвэл Аристотелийн “ярьдаг зэвсэг” гэж нэрлэсэн нийгмийн тэр хэсэг нийгмийн давхраажилтын аль хэв маягийг илэрхийлж байна вэ? (2 оноо)
- A. Анги B. Каст C. Язгуур
D. Боолчлол E. Аль нь ч биш
37. 1206-1921 он хүртэлх монголын нийгмийг давхраажилтын хувьд язгуурын хэв маягтай байсан гэж судлаачид үздэг. Тэгвэл энэ үеийн нийгмийн давхрааны бүтцийг тоочихдоо илүү зүйл дурьдсан бол аль нь вэ? (2 оноо)
- A. Лам нар B. Малчид C. Чөлөөт тариачид
D. Хаан, тайж, язгууртнууд E. Илүүц зүйл байхгүй
38. Нийгмийн нэг анги давхраанаас дээшлэх юм уу, доошлох шилжилтийг юу гэдэг вэ? (2 оноо)
- A. Босоо чиглэлт B. Хэвтээ чиглэлт C. Үе хоорондын
D. Үе доторх E. Хувийн
39. Нийгмийн бүтцийн өөрчлөлттэй холбогдон нийгмийн тодорхой бүлгийн гишүүдийн статуст өөрчлөлт гарах нь аль хэлбэрийн шилжих хөдөлгөөн бэ? (2 оноо)
- A. Хувийн B. Бүлгийн C. Босоо
D. Хэвтээ E. Үе хоорондын
40. Германы философич К. Маркс “Анги бол давхраажилтын хэмжигдэхүүн гэж үздэг” ба Марксизмд ангигүй нийгмийн тухай үзэл гол байр суурьтай билээ. Тэгвэл марксизмын үүднээс аль нь ангигүй нийгмийн хэлбэр вэ? (2 оноо)
- A. Феодалын нийгэм B. Капиталист нийгэм C. Боолт нийгэм
D. Хүй нэгдлийн нийгэм E. Зөв хариулт байхгүй
41. “Нийгмийн хөгжил нь ангигүй нийгмээс ангит нийгэмд, ангит нийгмээс ангигүй нийгэмд дэвшин явагддаг зүй тогтолтой бөгөөд төр яваандаа устаж үгүй болно” гэж үздэг сургаал аль нь вэ? (2 оноо)
- A. Марксизм-Ленинизм B. Соёл иргэншлийн онол C. Бихевиоризм
D. Позитивизм E. Эрчим хүчний онол

42. Өгөгдлийг зөв харгалзуул. (2 оноо)
- | | |
|-------------------------|---|
| 1. Нийгмийн эмзэг бүлэг | a. Хувь хүн юмуу гэр бүл, хүнс, хувцас, сууцтай байхад хүрэлцэх доод орлого |
| 2. Харьцангуй ядуурал | b. Өндөр настан, ажилгүйчүүд, олон хүүхэдтэй өрх, өрх толгойлсон эхчүүд |
| 3. Үнэмлэхүй ядуурал | c. Амьдралын боломжийн жишиг гэж тухайн нийгмийн үзэж байгаа зүйлсийг хангах чадваргүй байдал |
| 4. Ядуурлын босго | d. Амьдралын наад захын хэрэгцээгээ хангах чадваргүй байдал |
- A. 1d 2a 3b 4c B. 1d 2c 3a 4b C. 1a 2c 3b 4d
D. 1b 2c 3d 4a E. 1d 2c 3b 4a
43. Хувийн шилжих хөдөлгөөн хэрэгжих боломжтой нээлттэй давхраажилтын хэв маяг аль нь вэ? (2 оноо)
- A. Анги B. Боол C. Язгуур
D. Каст E. Бүгд
44. Соёл гэдэг ухагдахуун анхандаа ямар утгыг илэрхийлж байв? (2 оноо)
- A. Үйлдвэрлэлийн технологи боловсруулах
B. Сургалтын үйл явц
C. Хөрс боловсруулах, газар тариалан эрхлэх
D. Оюун ухааны үйл ажиллагаа
E. Эдгээрээс өөр
45. Зонхилогч соёл нь нийгмийн хэсэг бүлгийнхнийг бусдаас илүү эрх мэдэл, нэр хүндтэй болгож, нөгөө хэсгийг эрх мэдэл, нэр хүндгүй болгодог хэмээн ямар онол үздэг вэ? (2 оноо)
- A. Бүтэц үүргийн онол B. Угсаатны арга зүйн онол
C. Зөрчилдөөний онол D. Уламжлалт онол
E. Эдгээрээс өөр
46. Соёлын гадаад талыг илэрхийлдэг соёлын үндсэн элемент аль нь вэ? (2 оноо)
- A. Хэм хэмжээ B. Бэлгэ тэмдэг C. Үнэт зүйл
D. Хэл E. Эдгээрээс өөр
47. Аливаа нийгмийн зүйлсийн шинж, түүнчлэн хэрэгцээ хүсэл, эрмэлзлэл сонирхлыг хангагч үзэгдэл нь соёлын үндсэн элементийн аль нь вэ? (2 оноо)
- A. Хэл B. Үнэт зүйл C. Бэлгэ тэмдэг
D. Хэм хэмжээ E. Эдгээрээс өөр
48. Дараах өгөгдлүүдээс аль нь оюуны хэрэгцээг хангадаг вэ? (2 оноо)
- A. Иргэншил B. Соёл C. Нийгэм
D. Хот суурин E. Аль нь ч биш
49. Төрийн соёлын бодлого гэж юуг хэлэх вэ? (2 оноо)
- A. Үндэсний соёл, түүх дурсгалыг хамгаалах төрийн бодлого
B. Үндэсний соёл болон түүний бүтээгчдэд хамаарах төрийн бодлого
C. Нийгмийн урлаг, уран сайхныг хөгжүүлэх төрийн бодлого
D. Үндэсний бичиг үсгийг дэлгэрүүлэн хөгжүүлэх төрийн бодлого
E. Үндэсний чанартай юм бүгдийг дээдлэх, дэлгэрүүлэх бодлого
50. Өнөөдөр манай нийслэлд халх, буриад, казах, дөрвөд, дархад, урианхай зэрэг олон угсаатан ястан амьдрахаас гадна европ, ази, америк тивийн олон орнуудаас хүмүүс ирж амьдарч, ажиллаж байна. Энэ нь соёлын ямар бүрэлдэхүүнийг үүсгэж байна вэ?
- A. Элитийн соёл B. Дэд соёл C. Нийтийн соёл
D. Үндэсний соёл E. Эдгээрээс өөр
51. НҮБ-ын төв байр АНУ-ын Нью-Йорк хотод байрладаг. Түүний гол үндсэн байгууллагаас нэг нь л Голландын Гаага хотод байрладаг. Зөв хариуг ол. (2 оноо)
- A. Ерөнхий Ассамблей B. Аюулгүйн зөвлөл C. Эдийн засаг, нийгмийн зөвлөл
D. Асрамжийн зөвлөл E. Олон улсын шүүх
52. “Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон Олон улсын бусад үйл ажиллагаанд оролцуулах тухай” Монгол Улсын УИХ-аар 2002 онд баталсан хуулийн хүрээнд Монгол Улсын цэрэг хаана, хаана, ямар үйл ажиллагаа явуулсан бэ? (2 оноо)
- A. Африкийн гурван оронд хэрэгжүүлж буй энхийг сахиулах үйл ажиллагаанд ажиглагчаар оролцсон
B. Гадаад 10 гаруй оронтой хамтарсан хээрийн сургалт дадлагын ажлыг зохион байгуулсан
C. 2006 оноос Соерра Моне Улсад 250 хүнтэй цэргийн баг илгээсэн
D. 2003 оноос Ирак, Афганистанд энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож байна
E. Бүгд зөв

53. 1989 оны 5-р 16 нд Хятад-Зөвлөлтийн дээд хэмжээний уулзалтад ЗСБНХУ-ын сүүлчийн ерөнхийлөгч М. С. Горбачев, Хятадын төрийн тэргүүн Дэн Сяопин нар оролцсон нь 2 улсын хоорондын зөрчлийг албан ёсоор эцэс болгожээ. Энэ уулзалт олон улсын харилцааны аль төрөл, хэлбэрт хамаарах вэ? (2 оноо)
 А. Хоёр талт улс төрийн харилцаа
 В. Хоёр талт эдийн засгийн харилцаа
 С. Олон талт эдийн засгийн харилцаа
 D. Олон талт улс төрийн харилцаа
 E. Хоёр талт хүмүүнлигийн харилцаа
54. Монгол Улс 2004 онд 1-рт Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад, 2-рт Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээнд элсэн орсон. Зөв өгөгдлийг ол. (2 оноо)
 А. 1. ажиглагчаар; 2. гишүүнээр
 В. 1, 2 ажиглагчаар
 С. 1, 2 гишүүнээр
 D. 1. гишүүнээр; 2. ажиглагчаар
 E. Аль алинд нь элсээгүй
55. Монголчууд Хүннүгийн үеэс эхлэн хөрш орнуудтай элч илгээх, бичиг захидал солилцох, худалдаа наймаа хийх, худ ураг бололцох, найрамдах, дайтах зэргээр харилцаж ирсэн. Чухам энэ үеэс Монгол Улсын гадаад харилцааны үндсэн чиглэл тогтсон гэж үздэг. Энэ ямар чиглэл вэ? (2 оноо)
 А. “Хэн хүчтэй бол түүний зөв” гэсэн дайнч бодлого
 В. “Хүр хорхой навч идэх адил” хөршийнхөө нутгийг эзлэх
 С. Бусад үндэстнийг эрхшээлдээ авч уусган мөхөөх
 D. Энхийг эрхэмлэсэн шинжтэй бодлого
 E. Бусдын өмгөөлөл хамгаалалд орж амар аж төрөх
56. Дэлхий дахинд хоёр том лагерт хуваагдаж үзэл суртал, цэрэг зэвсэглэлийн талаар хөөцөлдөж байсан үе хэдий үеэс эцэс болсон бэ? (2 оноо)
 А. 1945
 В. 1960
 С. 1970
 D. 1990
 E. 1980
57. Өгөгдлийг зөв харгалзуул. (2 оноо)
 1. Олон улсын худалдааны тэнцвэрт өсөлтийг хангах a. WHO
 2. Хүмүүсийн амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, чанарыг дээшлүүлэх, ядуучуудын амьдралын нөхцөлийг сайжруулах b. IMF
 3. Эрүүл мэндийн бүх талын тусламж, үйлчилгээг хөгжүүлэх c. ILO
 4. Хүүхдийн хөдөлмөрийг зогсооход чиглэсэн үйл ажиллагааг авч явуулах d. World Bank
 А. 1d 2a 3b 4c
 В. 1d 2c 3a 4b
 С. 1b 2c 3d 4a
 D. 1b 2d 3a 4c
 E. 1d 2c 3b 4a
58. “Монгол Улсаас Дэлхийн байгаль, соёлын холимог өв”-д, “Дэлхийн соёлын өв”-д тус тус нэр дэвшүүлсэн зүйлийг ол. (2 оноо)
 А. Орхоны хөндийн түүх археологийн дурсгалууд
 В. Говь гурван сайхны байгалийн цогцолбор газар
 С. Увсын Их нуурын хотгорын байгалийн цогцолбор газар
 D. Хөвсгөл нуур ба бөө мөргөлтэй цаатангуудын газар
 E. А ба D зөв

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. Өгөгдлийг 2.1-д зөв харгалзуул. (А, В, С, D, E тус бүрд харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу). (5 оноо)
 А. Чек
 В. Электрон мөнгө
 С. Вексель
 D. Банкны мөнгөн тэмдэгт
 E. Депозит
 1. Тодорхой хугацаанд өрөө төлөх тухай зээлдэгчийн хүлээсэн үүргийг гэрчилсэн өр төлөх баталгаа
 2. Нэг данснаас нөгөө дансанд шилжүүлэх замаар хийгдэх банк хоорондын хадгаламжуудын тухай тооцооны систем
 3. Эмиссийн банкнаас гаргаж байгаа банкны мөнгөн тэмдэгт, тасалбарууд
 4. Тухайн банкнаас өөрийн харилцах данснаасаа мөнгө авах тухай бичихэд зориулагдсан данс өмчлөгчийн баримт
 5. Электрон тооцоолон бодох машины тусламжтай хийгдэх банкны тооцооны систем
- 2.2. Доорх соёлын хэлбэрүүдийг 2.2-д зөв харгалзуул. (А, В, С, D, E тус бүрд харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу). (5 оноо)
 А. Сонгодог соёл
 В. Ардын соёл
 1. Тодорхой бүлгийн зонхилгогч соёлоос ялгарах соёл
 2. Нийгмийн дээд давхрааны өндөр боловсрол шаардах соёл

- С. Хаалттай соёл
Д. Дэд соёл
Е. Зонхилох соёл

3. Ам дамжин уламжлагдсан эзэн зохиогчгүй үлгэр домог дуу
гэх мэтийг багтаасан соёл
4. Нийгмийн гишүүдэд нийтлэг байдлаар илрэх соёл
5. Соёлын өөр элементүүд нэвтрэх боломжгүй соёл

ХУВИЛБАР В

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Нийгмийн тогтолцоот чанарын талаас үүргийн хандлагын үндсэн ойлголтыг хэн анх “Социологийн үндэслэл” хэмээх бүтээлдээ боловсруулсан бэ? (2 оноо)
А. Г.Спенсер В. Р.Мертон С. Т.Парсонс
Д. К.Маркс Е. Эдгээрээс өөр
2. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. Хөгжлийн явцад хүмүүс хоорондоо хүссэн хүсээгүй ялгаралд орж байдаг. Жижиг бүлэгт бие бялдраараа ялгарч байдаг бол, томоохон орчинд ... ялгардаг гэж Г.Зиммель үзжээ. (2 оноо)
А. Эд баялгаар В. Эрх мэдлээр С. Оюун ухаанаар
Д. Боловсролоор Е. Бусад зүйлээр
3. Эзэлж буй статусаас хамаарч нийгмийн хүлээлтээр тодорхойлогдсон зан үйлийн хэмжээнүүдийн цогцыг юу гэдэг вэ? (2 оноо)
А. Нийгмийн хүлээлт В. Нийгмийн үүрэг С. Нийгмийн үйлдэл
Д. Нийгмийн функц Е. Эдгээрээс өөр
4. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. Нийгмийн өсөн нэмэгдэж буй ээдрээтэй байдлын шалтгаан, үр дагавар ... юм. (2 оноо)
А. Нийгмийн өөрчлөлт В. Нийгмийн хувьсал С. Хөдөлмөрийн хуваарь
Д. Нийгмийн дэвшил Е. Эдгээрээс өөр
5. Өгөгдлийг уншаад эртний шашны хэлбэрүүдээс зөвийг сонгоно уу. Өдөр тутмын практик үйл ажиллагаанаас өөр ялгаатай үйл үйлдлээр, хүн амьтны амьдрал, байгалийн үзэгдэлд нөлөөлж болно гэж үздэг үзэл. (2 оноо)
А. Маги В. Фетишизм С. Тотемизм
Д. Анимизм Е. Эдгээрээс өөр
6. Өгөгдлийг уншаад нийгмийн хэв маягийг сонгоно уу. Гэр бүл урьдын адил чухал үүрэгтэй байсан ч цэрэг, иргэний болон улс төрийн байгууллагын илүү хөгжилтэй хэлбэр тогтов. (2 оноо)
А. Агнуурын болон түүвэрлэгчдийн нийгэм
В. Цэцэрлэгийн аж ахуйн буюу энгийн тариалангийн нийгэм
С. Газар тариалангийн нийгэм
Д. Аж үйлдвэржсэн нийгэм
Е. Аж үйлдвэржсэний дараах нийгэм
7. Нийгмийн бүрдэл хэсгүүдийн хоорондын байнгын тогтвортой, эмхлэгдсэн, журамлагдсан, харилцаа холбооны цогц байдлыг тусгах ойлголт доорх өгөгдлөөс аль нь вэ? (2 оноо)
А. Нийгмийн байдал В. Нийгмийн бүтэц С. Нийгмийн үйлчлэл
Д. Нийгмийн үүрэг Е. Аль нь биш
8. Өсөлтийн үе шатны онолыг үндэслэгч У. Ростоу формацийн онолын эсрэг өөрийн үзлийг сөргүүлэн тавьсан байдаг. Тэрээр өөрийн онолоо ямар нэртэй зохиолдоо боловсруулан тавьсан бэ? (3 оноо)
А. “Европын мөхөл” В. “... Коммунист биш тунхаг”
С. Түүхийн Д. Луй Бонапарт брюмерын 18” Е. “Эртний нийгэм”
9. “Нийгэм бол хувьслын замаар хөгждөг ахуй мөн” гэж хэн хэлсэн бэ? (2 оноо)
А. Г.Спенсер В. О.Конт С. Н.Макиавелли
Д. Э.Дюркгейм Е. М.Вебер
10. Аж үйлдвэржсэний дараах нийгэмд юу голлох үүрэгтэй вэ? (2 оноо)
А. Сүм хийд, арми В. Корпорациуд С. Их сургуулиуд
Д. Төрийн бодлого Е. Эдгээрээс өөр
11. Цэгийн оронд тохирох хариултыг ол. Үндсэн хуульд зааснаар: Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд ... хамгаалалтад байна. (2 оноо)
А. Бүх нийтийн В. Тусгай С. Ард түмний
Д. Төрийн Е. Тохирох үг байхгүй
12. Дараах өгөгдлүүдээс аль нь илүүц вэ? Төрийн үндсэн шинжүүд нь түүнийг бусад улс төрийн байгууллагаас ялгаж өгдөг. Энэ нь ... (2 оноо)

- А. Албадлагын шинжтэй
 С. Дээд эрх мэдэл эдэлдэг шинжтэй
 Е. Сайн дурын шинжтэй
- В. Зайлшгүй шинжтэй
 D. Нийтлэг шинжтэй
13. Төр үүсэхэд нөлөөлсөн дараах хүчин зүйлсүүдээс илүүц нь аль вэ? (2 оноо)
 А. Хүмүүс үйлдвэрлэл явуулж, хэрэгцээгээ хангах орон зайтай байх үүднээс газар нутгаар зааглагдсан явдал
 В. Нийгмийн томоохон бүлгүүдийн хэрэгцээ сонирхолд гол гол ялгаа бий болж, Тэдгээрийн харилцааг зохицуулах үүднээс
 С. Хүмүүс газар нутгаа бусдаас хамгаалах үүднээс
 D. Нийгмийн тогтвортой байдлыг хангах үүднээс
 Е. Байгалийн объектив зүй тогтол
14. Аль нь зөв бэ? Аливаа улс төрийн намын туйлын зорилго нь: (2 оноо)
 А. Засгийн эрхийг гартаа авах
 В. Гишүүн элсүүлэх
 С. Үзэл баримтлал ижил, гадаадын улс төрийн намуудтай хамтран ажиллах
 D. Нам дэмжигчдээ улс төрийн талаар гэгээрүүлэх
 Е. Түүх, соёлын үнэт зүйлсүүдийг хамгаалах
15. Д.Истон улс төр хэмээх ойлголтыг хэрхэн тодорхойлсон бэ? (2 оноо)
 А. Улс төр нь засгийн эрх мэдлийг ашиглан нийгмийн дотор үнэт зүйлсийг хуваариалан байршуулах үйл ажиллагаа мөн
 В. Улс төр нь эрх мэдэлд хүрэх эрх мэдлийг тогтоон барьж байх болон ашиг хонжоо олохын тулд эрх мэдлийг ашиглах албадлагын арга хэрэгслийн цогц юм
 С. Улс төр нь эрх мэдэлд оролцох түүнийг хуваарилахад нөлөөлөхийн төлөө эрмэлзэн тэмцэх явдал юм
 D. Улс төр бол өөрсдийн нийгэм эдийн засгийн өвөрмөц ашиг сонирхол болон зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дэлхийн систем ба улс гүрэн, анги, түүний намаас явуулж байгаа тэмцэл, зөрчил нэвт шингэсэн нийгмийн амьдралын нэг хүрээ юм
 Е. Улс төр бол эрх мэдэл юм
16. “Соёл иргэншил мөхдөг шалтгаан нь ардчилалгүй буюу ардчилал урт насалж чадаагүй явдалтай холбоотой байсан” гэж хэн үзсэн бэ? (2 оноо)
 А. Т.Жефферсон
 В. А.Линкольн
 С. Ж.Тойнби
 D. У.Черчиль
 Е. Аль нь ч биш
17. Хадгаламж зээлийн хоршооны хохирогчдын түр хорооны төлөөлөгчид хохирлоо барагдуулах талаар шаардлага тавьж УИХ-ын даргатай уулзав. Энэ нь улс төрийн системийн ... юм. (2 оноо)
 А. Оролт
 В. Гаралт
 С. Дэмжлэг
 D. Эргэх холбоо
 Е. В ба С зөв
18. Улс төрийн системийг бүрдүүлэгч байгууллагуудыг дурьдахдаа илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ? (2 оноо)
 А. Нам
 В. Төр
 С. Сонирхлын бүлгүүд
 D. Үйлдвэр аж ахуйн газрууд
 Е. Бүгд зөв
19. Улс төрийн үйл ажиллагааны боломжит хувилбаруудаас хамгийн оновчтой илүү үр дүнтэйг нь эрх мэдэлдээ дулдуйдах, эсвэл зөвшилд хүрэх замаар сонгох үйл явцыг улс төрийн шинжлэх ухаанд гэж үздэг. Зөв хариултыг ол. (2 оноо)
 А. Улс төрийн шийдвэр
 В. Улс төрийн бодлого
 С. Улс төрийн дэглэм
 D. Улс төрийн ухамсар
 Е. Улс төрийн соёл
20. Төрийн засаглал гэсэн ойлголтод үл хамаарахыг ол. (2 оноо)
 А. Монгол Улсын ерөнхийлөгч айл гэр, албан газар болгон морин хуурыг хоймортоо залах тухай зарлиг гаргав
 В. УИХ-аас шинэчлэн найруулагдаж батлагдсан “Татварын багц хууль”-иуд 2007 оны I сарын 1-ээс Монгол Улс даяар мөрдөгдөж эхлэв
 С. БСШУ-ны сайдын тушаалаар ЕБС-ийн 1 цагийг 40 минутаар тооцох болов
 D. Ардчилсан намын дарга Ц.Элбэгдорж намынхаа бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт хийв
 Е. Төрийн албан хаагчдын цалинг Засгийн газрын ... дугаар тогтоолоор 20% нэмэв
21. Иргэн Ядам өөрийн санамсар болгоомжгүй үйлдлээс болж, гэмт хэрэг үйлдэж шүүхээс 4 жилийн ял шийтгэгджээ. Гэвч төр ивээж, түүнд уучлал үзүүлсэн байна. Төрийн уучлал үзүүлэх эрхийг хэн эдлэх вэ? (2 оноо)
 А. ЦЕГ
 В. Хууль зүйн сайд
 С. Улсын Дээд шүүх
 D. Ерөнхийлөгч
 Е. УИХ

22. Адам Смитын “Үл үзэгдэх гар” гэдэг нь юуны тухай ойлголт вэ? (2 оноо)
 А. Өрсөлдөөн В. Монополь С. Эрэлт
 D. Нийлүүлэлт E. Зах зээл
23. Төгс өрсөлдөөнт зах зээл дээр пүүсүүд үнэд яагаад нөлөөлж чаддаггүй вэ? (2 оноо)
 А. Бараа үйлчилгээний үнэ хоорондоо ижил учир
 В. Пүүсүүд үнээ өөрчлөвч ашиггүй тул үнэ өөрчлөх сонирхол байдаггүй
 С. Пүүсүүдийн үнэд засгийн газар хяналт тавьдаг
 D. Тухайн нэг пүүсийн зах зээлд эзлэх байр суурь бага
 E. Бараа үйлчилгээний үнэ хоорондоо адил биш учир
24. Доорх өгөгдлөөс макро эдийн засгийн судлах ойлголтыг ол. (2 оноо)
 А. Хэрэглэгч ба үйлдвэрлэгчийн онол
 В. Үйлдвэрлэлийн хэрэгсэл, ажиллах хүч
 С. Үнэт цаас, мэдээллийн зах зээл
 D. Зах зээлийн үнэ бүрдэлт
 E. Улсын мөнгөн гүйлгээнд өөрчлөлт оруулах
25. Гиффен бараа гэж юу вэ? Зөв өгөгдлийг сонго. (2 оноо)
 А. Үнэ нь өсөхөд эрэлт нь буурдаг бараа
 В. Үнэ нь өсөхөд эрэлт нь хэвээрээ байдаг бараа
 С. Үнэ нь буурахад эрэлт нь өсдөг бараа
 D. Үнэ нь буурахад эрэлт нь буурдаг бараа
 E. Үнэ тогтвортой, эрэлт нь тогтвортой бараа
26. Компани болон Засгийн газарт мөнгө хэрэгтэй болж, мөнгө зээлж авах зорилгоор бонд гаргадаг Тэгвэл бонд гэж юу вэ? (2 оноо)
 А. Тодорхой хэмжээний мөнгийг хэсэг хугацааны дараа төлөхөөр амласныг гэрчилсэн баримт
 В. Мөнгийг тодорхой хугацааны дараа төлөх болон татвар төлөх баримт
 С. Тодорхой хэмжээний мөнгийг тодорхой бус хугацаагаар хадгалуулсан баримт бичиг
 D. Компанид хөрөнгө оруулалт хийх үйлдэл
 E. Эдгээрээс өөр
27. Доорх өгөгдлөөс татварын орлогод багтах “Орлогын албан татвар”-ын зөв өгөгдлийг ол. (2 оноо)
 А. Нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамж
 В. Үл хөдлөх эд хөрөнгийн татвар
 С. Аж ахуйн нэгжүүд өөрийн ашгаасаа төлөх татвар
 D. Архи, тамхи, суудлын авто машин, авто бензин
 E. Улсын тэмдэгт, агнуурын нөөц ашигласан, ашигт малтмал зэрэг
28. Эдийн засгийн шинжлэх ухааны гол үүргийг тодорхойл. (2 оноо)
 А. Эдийн засгийн үйл ажиллагааг зохицуулах
 В. Эдийн засгийн үйл ажиллагааг зохион байгуулах
 С. Эдийн засгийн үйл ажиллагааг шийдвэрлэх
 D. Эдийн засгийн үйл ажиллагааны талаар таамаглал дэвшүүлэх
 E. Эдгээрээс өөр
29. Эдийн засгийн үйлдвэрлэлийн нөөц баялгийг газар, хөдөлмөр, капитал, үйлдвэрлэл, эрхлэх чадвар гэж 4 ангилдаг. Доорх өгөгдлүүдээс капиталын жишээг ол. (2 оноо)
 А. Ус, нар, салхины эрчим хүч, газрын тос, нүүрс, алт, ой мод, өвс ургамал
 В. Нийгэмд үр дүн, ашиг нь мэдрэгдэж, материаллаг болон оюуны үнэт зүйлийг бий болгоход чиглэгдсэн зорилготой үйл ажиллагаа
 С. Тоног төхөөрөмж, барилга, компьютер гэх мэтээр өөрөө үйлдвэрлэгдсэн, цаашдын үйлдвэрлэлд орц болон ашиглагдах бараа
 D. Газар, капитал, хөдөлмөр гэсэн нөөцийг нэг үйлдвэрийн газар нэгтгэн удирдах чадвар
 E. Хүмүүсийн хэрэгцээг хангахуйц бараа үйлчилгээг хийхэд шаардлагатай олон хүчин зүйлсийг нэгтгэх үйл явц
30. Нэг хүнд ноогдох үндэсний орлого нь харьцангуй өндөр мөртлөө тухайн улсын хөгжил сул байгаа нь юутай холбоотой вэ? (2 оноо)
 А. Хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого В. Татварын бодлого
 С. Гадаад дотоод худалдааны бодлого D. Мөнгөний бодлого
 E. Засгийн газрын зардал
31. Аль нь арилжааны банкны эрхлэх үйл ажиллагаа биш вэ? (2 оноо)
 А. Мөнгө гуйвуулах В. Мөнгө хадгалах С. Мөнгө гаргах
 D. Мөнгө үржүүлэх E. Эдгээрээс өөр

32. Мөнгө угаах гэмт хэрэг гэж юу? (2 оноо)
 А. Хар тамхи, зэвсгийн наймаа хийх
 В. Дээрэм хийх
 С. Хулгай тонуул хийх
 D. Хүний наймаа
 E. Хууль бус аргаар бүрдүүлсэн мөнгийг хуулиар зөвшөөрсөн эх үүсвэрээс олсон болгож хувиргах үйл ажиллагаа
33. Эдийн засгийн бодит хууль зүй тогтлыг таньж мэдэхэд аль нь тохирохгүй вэ? (2 оноо)
 А. График В. Анализ ба синтез С. Загварчлал
 D. Программчилал E. Эдгээрээс өөр
34. Нийгмийн хөгжил нь ангигүй нийгмээс ангит нийгэмд, ангит нийгмээс ангигүй нийгэмд дэвшин явагддаг зүй тогтолтой бөгөөд төр яваандаа устаж үгүй болно гэж үздэг сургаал аль нь вэ? (2 оноо)
 А. Марксизм-Ленинизм В. Соёл иргэншлийн онол С. Бихевиоризм
 D. Позитивизм E. Эрчим хүчний онол
35. Эрдэмтэн М. Вебер нийгмийн давхраажилтыг үндсэн 3 шалгуур хэмжигдэхүүнийг авч үзсэн байна. Үл хамаарахыг ол. (2 оноо)
 А. Эд баялаг В. Эрх мэдэл С. Нэр хүнд
 D. Үзэл бодол E. Аль нь ч биш
36. Монголын түүхэнд 1921-1990 оны үеийг социализмын үе гэж нэрлэдэг. Социализмын үед нийгмийн тэгш бус байдлыг арилгахыг эрмэлзэж байсан билээ. Тэгвэл энэ үед тэгш байдлыг тогтоохын тулд хамгийн гол нь юуг устгахыг зорьж байсан бэ? (2 оноо)
 А. Орлогын зөрөөг В. Арьс өнгөний ялгааг С. Хувийн өмчийг
 D. Нийгмийн өмчийг E. Боловсролын ялгааг
37. Эртний Грекийн Афин хотод ардчилал өндөр хөгжиж байжээ. Тэгвэл Афин хотын нийгмийн давхраажилтын байдал ямар нийгмийн шинжийг илэрхийлдэг вэ? (2 оноо)
 А. Нээлттэй нийгэм В. Өнөөгийн ардчилсан нийгэм С. Хаалттай нийгэм
 D. Кастын нийгэм E. Зөв хариулт байхгүй
38. Нийгмийн даатгалын төрлүүдийг зөв харгалзуул. (3 оноо)
 1. Тэтгэврийн даатгал а. Иргэн Долгор жирэмсэн тул ажлаасаа түр чөлөөлөгдсөн
 2. Тэтгэмжийн даатгал b. Иргэн Туул энэ сард өндөр насны тэтгэвэрт гарна
 3. Эрүүл мэндийн даатгал c. Иргэн Ёндон саяхан ажлаасаа халагдсан бөгөөд ажилгүй болсон тухайгаа дүүргийн хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүлсэн
 4. Үйлдвэрлэлийн осол ажил d. Барилгын компанид ажилладаг иргэн Эрдэнэ ажил үүргээ гүйцэтгэх үедээ хөлөө хугалсан мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал
 5. Ажилгүйдлийн даатгал e. Багш Энх дүүргийн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн
 A. 1d 2b 3c 4a 5e B. 1e 2b 3a 4c 5d C. 1b 2a 3e 4d 5c
 D. 1d 2b 3a 4c 5e E. 1b 2d 3c 4a 5e
39. Өмчийн тэгш бус байдлаар баталгаажсан, өөрөөр хэлбэл, эдийн засгийн ялгаанаас үүсэлтэй, харьцангуй нээлттэй, хувийн байр сууриа өөрчлөх боломжтой, давхраажилтын хэв маяг аль нь вэ? (2 оноо)
 А. Каст В. Боолчлол С. Язгуур
 D. Анги E. Аль нь ч биш
40. Эртний Энэтхэгийн домогт гардгаар кастын системийн нэгэн шат болох Шудра нар Прушу бурхны ямар эрхтнээс үүссэн бэ? (2 оноо)
 А. Гарнаас В. Хөлнөөс С. Гуянаас
 D. Уушигнаас E. Зүрхнээс
41. Судлаач Х. Гүндсамбуу социализмын үеийн Монголын нийгмийн давхраажилтыг 4 ангилан авч үзжээ. Үл хамаарахыг ол. (2 оноо)
 А. Хоршоолсон ард В. Ажилчин С. Сэхээтэн
 D. Номенклатур (Дарга анги) E. Хөрөнгөтний
42. Бие хүний бүлгийн давхраажилт дахь статусын эд баялаг, эрх мэдэл, нэр хүндэд дорвитой өөрчлөлт гаралгүйгээр өөрчлөгдөхийг юу гэх вэ? (2 оноо)
 А. Босоо чиглэлт В. Хэвтээ чиглэлт С. Үе хоорондын
 D. Үе доторх E. Хувийн
43. Аль онол соёл бол нийгмийн нягтралыг хангаж байдаг гэж үздэг вэ? (2 оноо)
 А. Бүтэц үүргийн онол В. Угсаатны арга зүйн онол С. Зөрчилдөөний онол
 D. Уламжлалт онол E. Марксист онол

44. Аливаа нийгмийн зүйлсийн шинж, түүнчлэн хэрэгцээ хүсэл, эрмэлзлэл сонирхолыг хангагч үзэгдэл нь соёлын үндсэн элементийн аль нь вэ? (2 оноо)
 А. Хэл В. Үнэт зүйл С. Бэлгэ тэмдэг
 D. Хэм хэмжээ E. Эдгээрээс өөр
45. Үнэлэмжийн тухай зөв тодорхойлолт аль нь вэ? (3 оноо)
 А. Үнэлэмж бол сайн, сайхан, шударга, хайр, буян зэрэг эерэг тогтвортой төсөөлөл юм.
 В. Үнэлэмж бол муу, муухай, нүгэл, шударга бус, бялдуучлал зэрэг тогтвортой сөрөг төсөөлөл юм
 С. Үнэлэмж бол сайн муу, сайхан муухай, зэрэг эерэг болон сөрөг шинжийг агуулсан тогтвортой төсөөлөл юм
 D. Үнэлэмж бол зөвхөн нийгмийн элит хэсгийнхний тогтвортой эрмэлзлэл юм.
 E. Дээрх буруу
46. Аль бодомж нь зөв бэ? (2 оноо)
 А. Соёл бол байгаль, нийгмийн үзэгдэл
 В. Соёл бол байгальд илрэх байдлын эсрэг үзэгдэл
 С. Соёл бол нийгмийн тогтонги ба өөрчлөмтгий шинжтэй үзэгдэл
 D. Соёл бол нийгэмд хааяа тохиолдох ховор үзэгдэл
 E. Бүгд буруу
47. Хүний туршлагыг хадгалж, дамжуулах, бодит хэлбэр болох соёлын үндсэн элемент аль нь вэ? (2 оноо)
 А. Хэм хэмжээ В. Бэлгэ тэмдэг С. Үнэт зүйл
 D. Хэл E. Эдгээрээс өөр
48. 1990 оны Монголд өрнөсөн ардчилсан өөрчлөлт нь соёлын аль элементэд багтах вэ? (2 оноо)
 А. Хэм хэмжээ В. Шашин С. Үнэт зүйл
 D. Хэл E. Алинд нь ч багтахгүй
49. Соёл урлаг хэмээх ойлголтуудын харилцааг зөв тодорхойл. (2 оноо)
 А. Энэ хоёр ойлголт эн тэнцүү ойлголт
 В. Соёл нь урлагаас өргөн, урлагийг өөртөө багтаана
 С. Урлаг нь соёлоос өргөн, соёлыг өөртөө багтаана
 D. Эдгээр институтуудад огтлолцох цэг байхгүй
 E. Эдгээрээс өөр
50. Соёлуудын харилцан тархалт дэлгэрэлтийг ямар үзэгдэл гэдэг вэ? (2 оноо)
 А. Соёлын харилцах үзэгдэл В. Соёлын дамжих үзэгдэл
 С. Соёлын хадгалагдах үзэгдэл D. Соёлын диффузи үзэгдэл
 E. А ба В зөв
51. Зөв харгалзуул. (2 оноо)
 1. ЮНЕСКО а. НҮБ-ын Хүүхдийн сан
 2. UNHCHR б. НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар
 3. ЮНИДО с. НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан соёлын байгуулал
 4. ЮНИСЕФ d. Үйлдвэр хөгжлийн байгууллага
 А. 1a 2c 3b 4d В. 1b 2d 3a 4c C. 1d 2a 3c 4b
 D. 1d 2c 3a 4b E. 1c 2b 3d 4a
52. Монгол Улс 2004 онд 1-рт Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад, 2-рт Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээнд элсэн орсон. Зөв өгөгдлийг ол. (2 оноо)
 А. 1. ажиглагчаар; 2. гишүүнээр В. 1, 2 ажиглагчаар
 С. 1, 2 гишүүнээр D. 1. гишүүнээр; 2. ажиглагчаар
 E. Аль алинд нь элсээгүй
53. Олон улсын харилцаанд өөрийгөө төлөөлөх тодорхой байгууллагаар дамжуулан харилцаж болдог, нилээд хязгаарлагдмал субъект аль нь вэ? (2 оноо)
 А. Олон улсын байгууллага В. Ард түмэн
 С. Төр засаг D. Үндэстэн дамнасан байгууллага
 E. А ба В зөв
54. Бүс нутаг, салбар бүс нутгийн интеграцлал, хүчтэй явагдаж, эдийн засгийн хөгжилд тулгуурласан хүчний төвүүд бий болж байна. Ийм байгууллагад хамааралгүй өгөгдлийг ол. (2 оноо)
 А. Европын холбоо В. Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо
 С. Ази Европын уулзалт D. Олон улсын Хөдөлмөрийн байгууллага
 E. Шанхайн хамтын ажиллагааны байгууллага
55. 1989 .5.16-нд Хятад-Зөвлөлтийн дээд хэмжээний уулзалтад ЗСБНХУ-ын сүүлчийн ерөнхийлөгч М. С. Горбачев, Хятадын төрийн тэргүүн Дэн Сяопин нар оролцсон нь 2 улсын хоорондын зөрчлийг албан ёсоор эцэс болгожээ. Энэ уулзалт олон улсын харилцааны аль төрөл, хэлбэрт хамаарах вэ? (2 оноо)

- А. Хоёр талт улс төрийн харилцаа
 В. Хоёр талт эдийн засгийн харилцаа
 С. Олон талт эдийн засгийн харилцаа
 D. Олон талт улс төрийн харилцаа
 E. Хоёр талт хүмүүнлигийн харилцаа
56. Н.Энхбаярын Засгийн газраас ОХУ-д төлөх “их өр”-ийн асуудлыг нааштайгаар шийдвэрлэсэн нь Монгол Улсын явуулж буй гадаад бодлогын алинд хамаарахгүй вэ? (2 оноо)
 А. Сайн хөршийн уламжлалт түншлэл
 В. Тэнцвэртэй гадаад бодлого
 С. Гадаад харилцааны олон талт үйл ажиллагаа
 D. Монгол Улсын идэвхтэй гадаад бодлого
 E. Үндэсний эрх ашигт нийцсэн гадаад бодлого
57. Монгол Улсаас “Дэлхийн утга соёлын шилдэг өвийн дээжис”-д нэр дэвшүүлсэн урлагийн төрөлд хамрагдахгүйг ол. (2 оноо)
 А. Хөөмий
 В. Уртын дуу
 С. Морин хуур
 D. Тууль
 E. Уран нугаралт
58. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 56-р чуулганд Монгол Улсын ерөнхийлөгч Н. Энхбаяр ямар утгатай үг хэлсэн бэ? (2 оноо)
 А. Терроризмтай хийх тэмцэлд оролцохоо илэрхийлсэн
 В. Терроризмын олон талт үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулахад оролцох боломжтой
 С. Терроризмтай тэмцэх Олон улсын хамтын нийгэмлэгийн хүч чармайлтыг тууштай дэмжихээ илэрхийлсэн
 D. Терроризмтай тэмцэхэд хүн хүчний тусламж үзүүлнэ
 E. Терроризмтай тэмцэхэд санхүү, эдийн засгийн дэмжлэг үзүүлнэ

ХОЁРУДГААР ХЭСЭГ

- 2.1. Өгөгдлийг 2.1-д зөв харгалзуул. (А, В, С, D, E тус бүрд харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу). (5 оноо)
 А. Үндэсний эдийн засгийн нэгдмэл үзүүлэлт
 В. ҮНБ
 С. ДНБ
 D. ҮЦБ
 E. Үндэсний орлого
1. Тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд дотооддоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлбэр
 2. Үндэсний цэвэр бүтээгдэхүүнээс худалдаа үйлчилгээний шууд бус татварыг хасаад үлдэх хэсэг
 3. Эх орны эдийн засгийн үзүүлэлтүүдийг үнэлэх олон улсын стандарт
 4. Нэг жилийн дотор үйлдвэрлэсэн бүх эцсийн үйлчилгээний зах зээлийн үнэ
 5. ҮНБ-ээс үйлдвэрлэлийн явцад элэгдсэн капиталын элэгдлийн шимтгэлийг хассанаар үүснэ
- 2.2. Дараах түүхэн нийтлэгүүдийг зөв харгалзуул. (А, В, С, D, E тус бүрд харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу). (5 оноо)
 А. Овог
 В. Аймаг
 С. Ястан
 D. Үндэстэн
 E. Угсаатан
1. Тодорхой газар нутгийн хүрээнд түүхэн ёсоор тогтсон соёл, сэтгэл зүйн шинж, онцлогийг хадгалсан урт хугацааны холбоотой том бүлэг хүмүүсийн тогтвортой цогц
 2. Хэл, газар нутаг, эдийн засаг, сэтгэл зүйн, соёлын нийтлэгийн үндсэн дээр түүхийн ёсоор бүрэлдэн тогтсон хүмүүсийн нийтлэг
 3. Гарал үүслийн нийтлэг, нэг хэл яриа, нийтлэг заншил, шүтлэг соёл аж байдлын шинжийг эзэмшсэн цусан төрлийн холбоо бүхий хүмүүс
 4. Нэг хэл яриа, зан заншил, шүтлэг, соёл, аж байдлын шинж бүхий тодорхой харьяалсан нутаг дэвсгэртэй, үлэмж олон хүмүүсээс бүрдсэн томоохон нийтлэг
 5. Нийтлэг хэл, сэтгэл зүйн онцлог, заншил, зан төрх, уламжлалаар бэхэжсэн аж төрөх ёс, соёлын онцлогоор холбогдсон нэг газар нутаг дээр оршин амьдрагч хүмүүсийн нийтлэг

ХУВИЛБАР С

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Нэгдэл холбоо нь өөрийн өмч болох нутаг дэвсгэртэй, уг нутаг дэвсгэр нь өөрийн нэр өөрийн түүхтэй гэж хэн хэлсэн бэ? (2 оноо)
А. Э. Шилз
В. Р. Мертон
С. Платон
D. Р. Марш
E. Аристотель
2. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. ... институт нь нийгмийн хүн амын нөхөн үйлдвэрлэлийг хангаж хойч үеийг өсгөн хүмүүжүүлэх функцийг хэрэгжүүлдэг. (2 оноо)
А. Улс төр
В. Эдийн засаг
С. Боловсрол
D. Гэр бүл
E. Хамт олон
3. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. Хувь хүмүүсийн хоорондын өдөр тутмын харилцааны явцад статусаас нь хамааран тодорхой, тогтвортой холбоо тогтох нь ... юм. (2 оноо)
А. Нийгмийн харилцаа
В. Нийгэм хоорондын харилцаа
С. Институт хоорондын харилцаа
D. Байгууллага, бүлэг, нийтлэл хоорондын харилцаа
E. Эдгээрээс өөр
4. Нийгмийн тогтвортой байдал нэгдлийг дэмжин тэтгэгч 3 гол институт байдаг ажээ. Илүүцийг ол.
А. Гэр бүл
В. Төр засаг
С. Шашин
D. Боловсрол
E. Эдгээрээс өөр
5. Өгөгдлийг уншаад эртний шашны хэлбэрүүдээс зөвийг сонгоно уу. Өдөр тутмын практик үйл ажиллагаанаас өөр ялгаатай үйл үйлдлээр, хүн амьтны амьдрал, байгалийн үзэгдэлд нөлөөлж болно гэж үздэг үзэл. (2 оноо)
А. Маги
В. Фетишизм
С. Тотемизм
D. Анимизм
E. Эдгээрээс өөр
6. Нийгмийг зөвхөн байгалийн хүчин зүйлээр тайлбарладаг үзлүүд байдаг ажээ. Тэгвэл Дарвины шалгарлын хуулиар нийгмийн хөгжлийг тайлбарласан биологийн сургаалтан хэн бэ? (3 оноо)
А. Л. Н. Гумилев
В. Монтескье
С. Ж. Тойнби
D. Ж. Гобино
E. Мечников
7. Германы социологч Ф.Тённис “Овгийн байгуулал ба нийгмийн байдал” хэмээх бүтээлдээ уламжлалт ба орчин үеийн нийгмийг ялгасан ажээ. Тэрээр аж үйлдвэржсэн хотын нийгмийг тайлбарлахдаа аль нэр томъёог хэрэглэсэн бэ? (2 оноо)
А. Гезельшафт
В. Гемейншафт
С. Нийгмийн нийтлэг
D. Өөрчлөн байгуулалтын онол
E. Аль нь биш
8. Аль нь төрөлх статус вэ? (2 оноо)
А. Би спортын гимнастикийн I зэрэгтэй
В. Би бага ангидаа Улаанбаатар хотын 1-р сургуульд сурч байв
С. Миний ээж харчин овогтой
D. Өвөө минь сайн малчин цолтой
E. Аль нь ч биш
9. Нийгмийн харилцан үйлчлэлийг өгөгдлөөс олно уу. (2 оноо)
А. Нийгмийн системийг бүрэлдүүлэгч хүчин зүйлс
В. Хүмүүс бие биедээ нөлөөлж, үйлчилж байдаг үйл явц
С. Хамтын үйл ажиллагааг нөхцөлдүүлэгч хүчин зүйлс
D. Объектив шинжтэй
E. Эдгээрээс өөр
10. Аж үйлдвэржсэн нийгэмд хэн голлох үүрэгтэй вэ? (2 оноо)
А. Шашны мяндаг тушаалтнууд, феодалууд
В. Бизнесменүүд
С. Төрийн удирдагчид
D. Эрдэмтэд, зөвлөх менежерүүд
E. Эдгээрээс өөр
11. Төлөөллийн ардчилалын сул талыг дурьдахдаа шууд ардчиллын сул талуудаас орсон бол аль нь вэ? (3 оноо)
А. Иргэдийн улс төрийн идэвх буурах талтай
В. Тодорхой субъект ихээхэн эрх мэдэлтэй ба удаан хугацаагаар сонгогддог
С. Цаг алдах төрийн бодлого шийдвэр боловсруулахад их хугацаа шаарддаг
D. Сонгогдсон субъект иргэдийн санаа бодлыг тэр бүр бүрэн илэрхийлж чадахгүй байх талтай
E. Шууд ардчиллын сул талаас дурьдагдаагүй

12. Улс төрийн бусад байгууллагаас төрийн ялгагдах гол онцлог шинж нь: (2 оноо)

А. Хамтын шийдвэр гаргадаг	В. Удирдагчтай
С. Гишүүнчлэлтэй	Д. Албадлага хэрэглэдэг
Е. Ялгаа байхгүй	
13. Оновчтойг сонго. Улс орны бүхий л хүрээг хамарсан улс төрийн бодлого боловсруулах, улс төрийн тогтолцоог бүрдүүлэхэд оролцох нь (2 оноо)

А. Сонирхлын бүлгийн үүрэг	В. Тухайн байгууллагын үүрэг
С. Хандивлагч орны үүрэг	Д. Улс төрийн намын үүрэг
Е. Зөв хариулт байхгүй	
14. Г.Лассуэл “Улс төр” хэмээх ойлголтыг хэрхэн тодорхойлсон бэ? (2 оноо)

А. Улс төр нь засгийн эрх мэдлийг ашиглан нийгмийн доторх үнэт зүйлийг хуваарилан байршуулах үйл ажиллагаа
В. Улс төр нь эрх мэдэлд хүрэх, түүнийг тогтоон барих болон ашиг хонжоо олохын тулд эрх мэдлийг ашиглах албадлагын арга хэрэгслийн цогц юм
С. Улс төр нь эрх мэдэлд оролцох түүнийг хуваарилахад нөлөөлөхийн төлөө эрмэлзэн тэмцэх явдал юм.
Д. Улс төр бол эрх мэдэл юм
Е. Улс төр бол хэн, юуг, хэзээ, хэрхэн олж, авч буй тэмцэл юм
15. “Ардчилал нь ард түмний тусын тулд тэдний өөрсдийнх нь бий болгосон засаг юм. Өөрөөр хэлбэл, ардчилал бол ард түмний засаглал юм” гэж хэн тодорхойлсон бэ? (2 оноо)

А. Т. Жефферсон	В. А. Линкольн	С. Ж. Тойнби
Д. У. Черчилль	Е. Аль нь ч биш	
16. Аль бодомж нь зөв бэ? (2 оноо)

А. Нам бол улс төрийн системийн гол цөм юм
В. Ард түмэн бол улс төрийн системийн гол цөм юм
С. Ардчилал бол улс төрийн системийн гол цөм юм
Д. Төр бол улс төрийн системийн гол цөм юм
Е. Зөв бодомж байхгүй
17. Төрийг байгууламжаар нь хэрхэн ангилдаг вэ? (2 оноо)

А. Холбооны, нэгдмэл, улсуудын холбоо (Конфедераци)
В. Ардчилсан, ардчилсан бус (авторитар, тоталитар)
С. Хаант, Бүгд найрамдах
Д. Хэмжээт, хэмжээгүй эрхт хаант
Е. Парламентын, ерөнхийлөгчийн
18. Монгол Улсын иргэн ИЗН-аас нэр дэвшигч С.Оюун 2004 онд УИХ-ын сонгуулийн 69 дүгээр тойрогт олонхийн санал авч УИХ-ын гишүүнээр сонгогдов Энэ нь улс төрийн системийн ... юм. (2 оноо)

А. Шаардлага	В. Гаралт	С. Дэмжлэг
Д. Эргэх холбоо	Е. А ба В	
19. Улс төрийн эрх мэдэл бүхий байгууллагаас олон түмний түгээмэл эрх ашигт нийцсэн дайчлан гаргах, хуваарилах, зохицуулах, дэмжлэг үзүүлэх чадвар бүхий тасралтгүй үйл явцыг улс төрийн шинжлэх ухаанд ... гэж үздэг. Зөв хариултыг ол. (2 оноо)

А. Улс төрийн шийдвэр	В. Улс төрийн бодлого	С. Улс төрийн дэглэм
Д. Улс төрийн ухамсар	Е. Улс төрийн соёл	
20. Төрийн засаглал гэсэн ойлголтод үл хамаарахыг ол. (2 оноо)

А. Монгол Улсын ерөнхийлөгч айл гэр, албан газар болгон морин хуурыг хоймортоо залах тухай зарлиг гаргав
В. УИХ-аас шинэчлэн найруулагдаж батлагдсан “Татварын багц хууль”-иуд 2007 оны I сарын 1-ээс Монгол Улс даяар мөрдөгдөж эхлэв
С. БСШУ-ны сайдын тушаалаар ЕБС-ийн 1 цагийг 40 минутаар тооцох болов
Д. Ардчилсан намын дарга Ц. Элбэгдорж намынхаа бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт хийв
Е. Төрийн албан хаагчдын цалинг Засгийн газрын ... дугаар тогтоолоор 20% нэмэв
21. 2002 онд Монгол Улсын “Иргэний хууль” шинэчлэгдэн батлагдсан бөгөөд энэ хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар хэрэгтэй болсон. Энэхүү тайлбарыг хэн хийх вэ? (2 оноо)

А. Засгийн газар	В. Үндсэн хуулийн цэц	С. Улсын Дээд шүүх
Д. Ерөнхийлөгч	Е. УИХ	
22. Сурагч Бат өвлийн амралтаараа олимпиадад бэлтгэх мөн чөлөөт цагаараа ажил хийх зорилготой байлаа. Эдгээр ажлыг зэрэг хийх боломжгүй тул олимпиадад бэлтгэхэд амралтаа зориулав. Батын алдагдсан боломжийн өртгийг тодорхойл. (2 оноо)

- А. Алдагдсан боломжийн өртөг байхгүй. Учир нь тэр мөнгө зарцуулаагүй
В. Хичээлийн олимпиадад бэлтгэх
С. Ажиллах
D. Гэртээ байх
E. Эдгээрээс өөр
23. Нэг хүнд ноогдох үндэсний орлого нь харьцангуй өндөр мөртлөө тухайн улсын хөгжил сул байгаа нь юутай холбоотой вэ? (2 оноо)
А. Хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого
В. Татварын бодлого
С. Гадаад дотоод худалдааны бодлого
D. Мөнгөний бодлого
E. Засгийн газрын зардал
24. Албан татварын гол зарчимд хамааралгүй утгыг ол. (2 оноо)
А. Иргэн аж ахуйн нэгж
В. Хууль тогтоомжоор тогтоогдох
С. Тогтоосон хугацаа
D. Хувь хэмжээ
E. Дүрмийн бус сан
25. Цалин хөлс өрхийн орлогын ихэнхийг бүрдүүлдэг. Хүний хөдөлмөрийг ашигласны төлөө түүний тоо чанарт нийцүүлэн төлөх мөнгөн төлбөрийг цалин хөлс гэнэ. Тэгвэл ямар цалингийн хэмжээ орлогын ерөнхий түвшинг харуулах боловч хүний амжиргааны түвшинг харуулдаггүй вэ? (2 оноо)
А. Бодит цалин
В. Цагаар олгох
С. Нэрлэсэн цалин
D. Хийснээр олгох цалин
E. Эдгээрээс өөр
26. Чи хурд сайтай хамгийн сүүлийн үеийн компьютер авах санхүүгийн боломжтой. Гэвч чамд чиний хүссэн компьютер олдохгүй байна. Үүнийг эдийн засгийн ухаанд юу гэж тодорхойлдог вэ? (2 оноо)
А. Эрэлт
В. Хүсэл
С. Хэрэгцээ
D. Сонирхол
E. Хүслээ хэрэгжүүлэх бэлэн байдал
27. Гиффен бараа гэж юу вэ? Зөв өгөгдлийг сонго. (2 оноо)
А. Үнэ нь өсөхөд эрэлт нь буурдаг бараа
В. Үнэ нь өсөхөд эрэлт нь хэвээрээ байдаг бараа
С. Үнэ нь буурахад эрэлт нь өсдөг бараа
D. Үнэ нь буурахад эрэлт нь буурдаг бараа
E. Үнэ тогтвортой, эрэлт нь тогтвортой бараа
28. Далд эдийн засаг гэдэг ойлголттой доорх өгөгдлөөс аль хамааралгүй вэ? (2 оноо)
А. Иргэн Дорж тахир дутуугийн тэтгэвэр авдаг. Олон жил ганзагын наймаа хийсэн боловч татвар төлдөггүй нэгэн
В. Багш Тулга МУИС-д багшлахын зэрэгцээ арван жилийн 1-р сургуульд ажилладаг
С. Хямд үнэтэй хятад барааг иргэн Дулмаа нэгэн албан байгууллагад өндөр үнээр нийлүүлэв
D. Нярав ажилтай Сандаг байгууллагын мөнгөөр гаднаас ихээхэн бараа авч ирж худалдаад ашиг олов
E. Байгууллагын дарга Мөнх нэгэн албан тушаалд ажиллуулах хүнээсээ ихээхэн мөнгийг урамшил болгон авчээ
29. Ханш уналтаас ямар зүйл хамгаалж чаддаг вэ? (2 оноо)
А. Мөнгөн хуримтлал
В. Үл хөдлөх хөрөнгө үнэт цаас
С. Найдвартай хүнд зээлдүүлсэн мөнгө
D. “Голомт” банкинд хадгалуулсан мөнгө
E. Эдгээрээс өөр
30. ҮНБ-ийг хэмжиж тодорхойлоход холбогдох өгөгдлийг ол. (2 оноо)
А. Үр тарианы аж ахуйгаас нийлүүлсэн түүхийн эдийн үнэ
В. Дэлгүүрт борлогдох талхны үнийн хэмжигдэхүүн
С. Гурилын үйлдвэрт худалдсан үр тарианы үнэ
D. Өмнөх жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнэ
E. Эдгээрээс өөр
31. Хөдөлмөрийн зах зээл дээр ажилгүйдэл ямар үед их өсдөг вэ? (2 оноо)
А. Ажил хайгч хүмүүсийн тоо ажлын байрнаас их үед
В. Ажил хайгч хүмүүсийн тоо ажлын байрнаас бага үед
С. Ажил хайгч хүмүүсийн тоо ажилтай хүмүүсээс их
D. Ажил хайгч хүмүүсийн тоо ажилтай хүмүүсээс бага
E. Ажил хайгч хүмүүсийн тоо ажлын байр тэнцвэртэй тохиолдолд

32. Монгол Улсын нутаг дээр үйл ажиллагаа явуулдаг гадаадын үйлдвэрүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдхүүн манай улсын ДНБ-нд тооцогдох уу? (2 оноо)
 А. Гадаадын хөрөнгө оруулалттай тул тооцогдохгүй
 В. Хамтын хөрөнгө оруулалттай тул тооцогдохгүй
 С. Тухайн компани өөрийн орондоо тооцогдоно
 D. Манай улсын ДНБ-нд тооцогдоно
 E. Эдгээрээс өөр
33. Альфред Маршалл хүн төрөлхтний хэвийн амьдралын үйл ажиллагааны тухай сургаалыг юу гэж товчоор тодорхойлсон бэ? (2 оноо)
 А. Хүний хөгжил В. Эдийн засаг С. Үйлдвэрлэл
 D. Аж үйлдвэржилт E. Амьдралын нөхцөл
34. Нээлттэй нийгмийн үзэл санааг боловсруулж "... түүний дайснууд" хэмээх номыг бичсэн хүн хэн бэ? (2 оноо)
 А. Б.Рассель В. К.Поппер С. К.Маркс
 D. М.Вебер E. Зөв хариулт байхгүй
35. Зан заншил юмуу хуулиудаар баталгаажсан угсаа залгамжилдаг нийгмийн давхараажилтын хэв маяг аль нь вэ? (2 оноо)
 А. Каст В. Боолчлол С. Язгуур
 D. Анги E. Аль нь ч биш
36. Өгөгдлийг зөв харгалзуул. (2 оноо)
 1. Ядуус a. Амьдралын наад захын хэрэгцээгээ хангах чадваргүй байдал
 2. Нэн ядуу b. Төрөөс тогтоосон амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэд
 3. Үнэмлэхүй ядуурал c. Өрхийн нэг хүнд оногдох орлого нь амжиргааны доод түвшний 40%-д хүрэхгүй байх
 4. Харьцангуй ядуурал d. Амьдралын боломжийн жишиг гэж тухайн нийгмийн байгаа зүйлсийг хангах чадваргүй байдал
 А. 1b 2c 3a 4d В. 1c 2a 3d 4b С. 1b 2a 3c 4d
 D. 1a 2b 3c 4d E. 1d 2a 3c 4b
37. Эртний Грекийн хот улсуудад ардчилал өндөр хөгжиж байжээ. Тэгвэл Эртний Грекийн хот улсууд дахь нийгмийн давхраажилтын байдал ямар нийгмийн шинжийг илэрхийлдэг вэ? (2 оноо)
 А. Нээлттэй нийгэм В. Өнөөгийн ардчилсан нийгэм
 С. Хаалттай нийгэм D. Кастын нийгэм
 E. Зөв хариулт байхгүй
38. Нийгмийн халамжийн хэлбэрүүдийг зөв харгалзуул. (3 оноо)
 1. Нийгмийн халамжийн тэтгэвэр a. 10 настай өнчин Болд хүүхдийн асрах газар өсөж хүмүүжиж байгаа
 2. Нийгмийн халамжийн тэтгэмж b. Иргэн Гомбо 70 настай, тэрээр урд өмнө ажил хийж байгаагүй боловч улсаас тодорхой хэмжээний мөнгө авдаг
 3. Нийгмийн асрамжийн үйлчилгээ c. Иргэн Отгон олон хүүхэдтэй, түүнд улсаас тодорхой хугацаанд мөнгөн тусламж үзүүлдэг
 4. Нийгмийн халамжийн үйлчилгээ d. "Өсөх" компани дүүргийн харж, хандах хүнгүй ахмадуудыг хүлээн авч, цайллага хийв
 А. 1d 2b 3c 4a В. 1e 2b 3a 4c С. 1b 2c 3a 4d
 D. 1d 2b 3a 4c E. 1b 2d 3c 4a
39. Эрдэмтэн М. Вебер нийгмийн давхраажилтыг үндсэн 3 шалгуур хэмжигдэхүүнийг авч үзсэн байна. Үл хамаарахыг ол. (2 оноо)
 А. Эд баялаг В. Эрх мэдэл С. Нэр хүнд
 D. Үзэл бодол E. Аль нь ч биш
40. 1206-1921 он хүртэлх монголын нийгмийг давхраажилтын хувьд язгуурын хэв маягтай байсан гэж судлаачид үздэг. Тэгвэл энэ үеийн нийгмийн давхрааны бүтцийг тоочихдоо илүү зүйл дурьдсан бол аль нь вэ? (2 оноо)
 А. Лам нар В. Малчид С. Чөлөөт тариачид
 D. Хаан, тайж, язгууртнууд E. Илүүц зүйл байхгүй
41. Өмчийн тэгш бус байдлаар баталгаажсан, өөрөөр хэлбэл, эдийн засгийн ялгаанаас үүсэлтэй, харьцангуй нээлттэй, хувийн байр сууриа өөрчлөх боломжтой, давхраажилтын хэв маяг аль нь вэ? (2 оноо)
 А. Каст В. Боолчлол С. Язгуур
 D. Анги E. Аль нь ч биш

42. Шашны номлол, зан үйлээр баталгааждаг давхраажилтын хэв маяг аль нь вэ? (2 оноо)
 А. Каст В. Боолчлол С. Язгуур
 D. Анги E. Аль нь ч биш
43. Тодорхой бие хүний амьдрал, үйл ажиллагааны явцад түүний статуст өөрчлөлт гарах нь ямар хэлбэрийн шилжих хөдөлгөөн бэ? (2 оноо)
 А. Хувийн В. Бүлгийн С. Босоо
 D. Хэвтээ E. Нийтийн
44. Хүний оюун санааны бодит биелэл бөгөөд байгаль, нийгмийн гадаад зүй зохисоос үл хамааран хүний өөрийн үнэт, нандин чанарт тулгуурладаг хүчин зүйл. (2 оноо)
 А. Хэм хэмжээ В. Зан суртахуун С. Үнэт зүйл
 D. Хэл E. Урлаг
45. Төрийн соёлын бодлого гэж юуг хэлэх вэ? (2 оноо)
 А. Үндэсний соёл, түүх дурсгалыг хамгаалах төрийн бодлого
 В. Үндэсний соёл болон түүний бүтээгчдэд хамаарах төрийн бодлого
 С. Нийтийн урлаг, уран сайхныг хөгжүүлэх төрийн бодлого
 D. Үндэсний бичиг үсгийг дэлгэрүүлэн хөгжүүлэх төрийн бодлого
 E. Үндэсний чанартай юм бүгдийг дээдлэх, дэлгэрүүлэх бодлого
46. Эдгээрээс аль нь соёлын институт биш вэ? (2 оноо)
 А. Шашин В. Домог зүй
 С. Байгаль D. Урлаг
 E. А ба В зөв
47. Соёлуудын харилцан тархалт дэлгэрэлтийг ямар үзэгдэл гэдэг вэ? (2 оноо)
 А. Соёлын харилцах үзэгдэл В. Соёлын дамжих үзэгдэл
 С. Соёлын хадгалагдах үзэгдэл D. Соёлын диффузи үзэгдэл
 E. А ба В зөв
48. Зонхилогч соёл нь нийгмийн хэсэг бүлгийнхнийг бусдаас илүү эрх мэдэл, нэр хүндтэй болгож, нөгөө хэсгийг эрх мэдэл, нэр хүндгүй болгодог хэмээн ямар онол үздэг вэ? (2 оноо)
 А. Бүтэц үүргийн онол В. Угсаатны арга зүйн онол
 С. Зөрчилдөөний онол D. Уламжлалт онол
 E. Эдгээрээс өөр
49. Хүнд зайлшгүй хэрэгтэй бүгдээс илүү дээгүүр гэдгийг хүлээн зөвшөөрч, түүнд тэмүүлж, ихэд хүндэтгэн дээдэлж, биширч харилцдаг хүний мэдрэмж, амьдралын үнэт чиглэлийг үнэт чанар гэдэг ажээ. Тэгвэл үнэт чанарыг судалдаг ухааныг юу гэдэг вэ? (2 оноо)
 А. Аксеологи В. Археологи
 С. Түүх D. Антропологи
 E. Эдгээрээс өөр
50. Доорх өгөгдлөөс буруу утгыг ол. (2 оноо)
 А. Соёл хүнд удамшин дамждаг В. Соёл хүнд удамшин дамждаггүй
 С. Соёлыг өнөө үед сэргээн амьдруулдаг D. Соёлыг дараагийн үедээ дамжуулдаг
 E. Буруу утга байхгүй
51. Төсөөлөл, үнэт зүйл, мэдлэг, үзэл суртал, хэл яриа, оюуны үйлдвэрлэл эдгээр нь социологийн шинжлэх ухааны үүднээс ямар соёлд орох вэ? (2 оноо)
 А. Нийтийн соёл В. Материаллаг соёл
 С. Материаллаг бус соёл D. Дэд соёл
 E. Эдгээрээс өөр
52. Хэдээс дээш улс оролцож байгуулсан хамтын байгууллагыг олон улсын байгууллага гэх вэ? (2 оноо)
 А. 2 В. 3 С. 4 D. 5 E. 6
53. Бүс нутаг, салбар бүс нутгийн интеграцлал, хүчтэй явагдаж, эдийн засгийн хөгжилд тулгуурласан хүчний төвүүд бий болж байна. Ийм байгууллагад хамааралгүй өгөгдлийг ол. (2 оноо)
 А. Европын холбоо В. Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо
 С. Ази Европын уулзалт D. Олон улсын Хөдөлмөрийн байгууллага
 E. Шанхайн хамтын ажиллагааны байгууллага
54. Эдгээр байгууллагуудын гол үүрэгт дараах үйл ажиллагааны чиглэлүүд багтана. (2 оноо)
 1. Өнөөгийн дэлхий нийтийн хөгжлийн гол чиглэлийг дэмжих, оюуны болон ёс суртахууны чиглүүлэгч хүч болох а. ЮНИСЕФ
 2. Хүмүүсийн дунд нөхөн үржихүйн зөв таатай орчныг бүрдүүлэх б. Хүн амын сан

3. Хүүхдийн эрхийг хамгаалах, тэдний үндсэн хэрэгцээг хангахад тусласан
4. Дэлхийн хөгжиж буй орнуудад ядуурлыг бууруулахыг чухалчлах
5. Гэрээг амьдралд хэрэгжүүлэх талаар гишүүн орнуудын авч явуулсан арга хэмжээний илтгэлийг судлах
A. 1d 2b 3c 4a 5e B. 1e 2b 3a 4c 5d C. 1b 2a 3c 4d 5b
D. 1d 2b 3a 4c 5e E. 1b 2d 3c 4a 5e
55. Н.Энхбаярын Засгийн газраас ОХУ-д төлөх “их өр”-ийн асуудлыг нааштайгаар шийдвэрлэсэн нь Монгол Улсын явуулж буй гадаад бодлогын алинд хамаарахгүй вэ? (2 оноо)
A. Сайн хөршийн уламжлалт түншлэл B. Тэнцвэртэй гадаад бодлого
C. Гадаад харилцааны олон талт үйл ажиллагаа D. Монгол Улсын идэвхтэй гадаад бодлого
E. Үндэсний эрх ашигт нийцсэн гадаад бодлого
56. НҮБ-ын төв байр АНУ-ын Нью-Йорк хотод байрладаг. Түүний гол үндсэн байгууллагаас нэг нь л Голландын Гаага хотод байрладаг. Зөв хариуг ол? (2 оноо)
A. Ерөнхий Ассамблей B. Аюулгүйн зөвлөл
C. Эдийн засаг, нийгмийн зөвлөл D. Асрамжийн зөвлөл
E. Олон улсын шүүх
57. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Финлянд Улсын Засгийн газар хоорондын “Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай” хэлэлцээрт Үйлдвэр, худалдааны сайд Ц. Даваадорж, Финлянд Улсаас манай оронд суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Анти Коузмини нар өчигдөр албан ёсоор гарын үсэг зурлаа. Энэ хэлэлцээр нь хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх, финляндын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм. Энэ ямар талт харилцаанд хамаарах вэ? (2 оноо)
A. Хоёр талт улс төрийн харилцаа B. Хоёр талт эдийн засгийн харилцаа
C. Олон талт эдийн засгийн харилцаа D. Олон талт улс төрийн харилцаа
E. Хоёр талт хүмүүнлигийн харилцаа
58. Монголчууд Хүннүгийн үеэс эхлэн хөрш орнуудтай элч илгээх, бичиг захидал солилцох, худалдаа наймаа хийх, худ ураг бололцох, найрамдах, дайтах зэргээр харилцаж ирсэн чухам энэ үеэс Монгол Улсын гадаад харилцааны үндсэн чиглэл тогтсон гэж үздэг. Энэ ямар чиглэл вэ? (2 оноо)
A. “Хэн хүчтэй бол түүний зөв” гэсэн дайнч бодлого
B. “Хүр хорхой навч идэх адил” хөршийнхөө нутгийг эзлэх
C. Бусад үндэстнийг эрхшээлдээ авч уусган мөхөөх
D. Энхийг эрхэмлэсэн шинжтэй бодлого
E. Бусдын өмгөөлөл хамгаалалд орж амар аж төрөх

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. Инфляцийн бүтэц ангилалыг 2.1-д зөв харгалзуул. (A, B, C, D, E тус бүрд харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу). (5 оноо)
A. Ил инфляци 1. Мөнгө өөрийн үүргээ бүх талаар алдсан үед бий болох инфляци
B. Далд инфляци 2. Амжиргааны үнэ өсөх хүн амын орлогын дутагдал, барааны хомсдол зэргээс болж төрийн ямар нэг дэмжлэггүй үүсдэг инфляци
C. Эрэлтийн инфляци 3. Төрийн мөнгөний бодлогоос хамаарч үүсдэг инфляци
D. Нийлүүлэлтийн инфляци 4. Үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн үнэ өссөнөөс үйлдвэрлэгч өөрийн өндөр зардлыг нөхөх шаардлагаар бүтээгдэхүүний үнийг нэмснээс үүсдэг инфляци
E. Хэтрүү инфляци 5. Үйлдвэрлэл буурч, бараа материал ховордсоноос үүсч байгаа инфляци
- 2.2. Өгөгдлийг 2.2-д зөв харгалзуул. (A, B, C, D, E тус бүрд харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу). (5 оноо)
A. Нийгмийн холбоо 1. Бодьгал ба нийгмийн бүлгүүдийн хооронд тогтсон харьцангуй тогтвортой, бие даасан холбоо хамаарал
B. Нийгмийн харилцан үйлчлэл 2. Тодорхой зорилго, эрх ашиг өвөрлөн түүндээ хүрэхийн тулд эдийн засаг, улс төр, үзэл суртлын төрөл бүрийн арга хэрэгсэл ашиглан хийж буй нийгмийн ач холбогдол бүхий үйлдлүүдийн цогц
C. Нийгмийн үйлдэл 3. Хүлээлтийг өөртөө агуулсан үйл ажиллагааны энгийн нэгж

- | | |
|---------------------------|--|
| D. Нийгмийн харилцаа | 4. Аливаа нэг зорилтыг шийдэх үүднээс тодорхой цаг үед, тухайн нийтлэгийн хүрээнд хамтын үйл үйл ажиллагааг нөхцөлдүүлэгч баримт материалуудын цуглуулга |
| E. Нийгмийн үйл ажиллагаа | 5. Хүмүүс бие биедээ нөлөөлж, үйлчилж, байдаг үйл явц. Энэ нь нийгмийн шинэ харилцаа төлөвшихөд хүргэдэг |

ХУВИЛБАР D

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Анх “социологи” хэмээх нэр томъёог хэрэглэн, нийгмийг шинжлэх ухааны үүднээс судлах зорилгыг хэн дэвшүүлсэн бэ?
A. Ж.Руссо
B. О.Конт
C. Платон
D. Т.Гоббс
E. Ж.Локк
2. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. ... институт нь нийгмийн эв нэгдэл, зөвшилцлийг тогтоох чиг үүргийг хүлээдэг. (2 оноо)
A. Улс төр
B. Шашин
C. Боловсрол
D. Гэр бүл
E. Хамт олон
3. Өгөгдлийг уншаад нийгмийн хэв маягийг сонгоно уу. Гэр бүл урьдын адил чухал үүрэгтэй байсан ч цэрэг, иргэний болон улс төрийн байгууллагын илүү хөгжилтэй хэлбэр тогтов. (2 оноо)
A. Агнуурын болон түүвэрлэгчдийн нийгэм
B. Цэцэрлэгийн аж ахуйн буюу энгийн тариалангийн нийгэм
C. Газар тариалангийн нийгэм
D. Аж үйлдвэржсэн нийгэм
E. Аж үйлдвэржсэний дараах нийгэм
4. Аль нь төрөлх статус вэ? (2 оноо)
A. Би спортын гимнастикийн I зэрэгтэй
B. Би бага ангид Улаанбаатар хотын 1-р сургуульд сурч байв
C. Миний ээж харчин овогтой
D. Өвөө минь сайн малчин цолтой
E. Аль нь ч биш
5. Нуклеар гэр бүл баяртай гэж, өндөр хөгжилтэй орнуудад бичих болсон ажээ. Үүнийг юу гэж ойлгох вэ? (2 оноо)
A. Ганц бие хүмүүсийн тооны өсөлт
B. Ижил хүйстнүүдийн гэрлэлт
C. Эхнэр, нөхөр бүтцийн өсөлт
D. Нөхөр, эхнэр, хүүхэд бүтцийн бууралт
E. Аль нь биш
6. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. Хувь хүмүүсийн хоорондын өдөр тутмын харилцааны явцад статусаас нь хамааран тодорхой, тогтвортой холбоо тогтох нь ... юм. (2 оноо)
A. Нийгмийн харилцаа
B. Нийгэм хоорондын харилцаа
C. Институт хоорондын харилцаа
D. Байгууллага, бүлэг, нийтлэл хоорондын харилцаа
E. Эдгээрээс өөр
7. Аж үйлдвэржсэнээс өмнөх нийгмийн гол зорилго юу вэ? (2 оноо)
A. Засаглал
B. Мөнгө
C. Мэдлэг мэдээлэл
D. Эдгээрээс өөр
E. Татвар
8. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд гэр бүлийг тодорхойлохдоо “Гэр бүл гэж гэрлэлтийн үр дүнд бий болсон, эд хөрөнгийн бус, амины болон эд хөрөнгийн эрх үүргээр холбогдсон ... хэлнэ”. (2 оноо)
A. Хамтын амьдрал бүхий гэр бүлийг
B. Хамтын амьдрал бүхий гэр бүл, гишүүдийг
C. Хамтын амьдрал бүхий эхнэр, нөхрийг
D. Хамтын амьдрал бүхий нөхөр, эхнэр, үр хүүхдийг
E. Аль нь биш
9. Эзэлж буй статусаас хамаарч нийгмийн хүлээлтээр тодорхойлогдсон зан үйлийн хэмжээнүүдийн цогцыг юу гэдэг вэ? (2 оноо)
A. Нийгмийн хүлээлт
B. Нийгмийн үүрэг
C. Нийгмийн үйлдэл
D. Нийгмийн функц
E. Эдгээрээс өөр

10. Сүхбаатарын талбай дээр зөвшөөрөлгүй цугларч, төрийн ордон руу элдэв зүйлийг шидэлж, юм балбаж, орилж хашгирч, нийгмийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг зөрчих байдлыг юу гэдэг вэ? (2 оноо)
 - А. Жигшүүрт үйлдэл
 - В. Сөрөг үйлдэл
 - С. Аноми байдал
 - Д. Гэмт хэрэг
 - Е. Эдгээрээс өөр
11. Монгол Улсын Үндсэн хуулин дахь заалт аль нь вэ? (2 оноо)
 - А. Монгол Улс бол Бүгд найрамдах засаглалтай бүрэн эрхт улс мөн
 - В. Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн
 - С. Монгол Улс бол Бүрэн эрхт улс мөн
 - Д. Монгол Улс бол тусгаар тогтносон улс мөн
 - Е. Аль нь ч биш
12. Төрийн улс төрийн бусад байгууллагаас ялгагдах гол онцлог шинж нь: (2 оноо)
 - А. Хамтын шийдвэр гаргадаг
 - В. Удирдагчтай
 - С. Гишүүнчлэлтэй
 - Д. Албадлага хэрэглэдэг
 - Е. Ялгаа байхгүй
13. Иргэн Гомбожав шүүгч болох болзлыг хангажээ. Түүнийг хэн шүүгчээр томилох вэ? (2 оноо)
 - А. УИХ
 - В. Засгийн газар
 - С. Улсын дээд шүүх
 - Д. Ерөнхийлөгч
 - Е. Шүүхийн ерөнхий зөвлөл
14. Аль бодомж нь зөв бэ? (2 оноо)
 - А. Нам бол улс төрийн системийн гол цөм юм
 - В. Ард түмэн бол улс төрийн системийн гол цөм юм
 - С. Ардчилал бол улс төрийн системийн гол цөм юм
 - Д. Төр бол улс төрийн системийн гол цөм юм
 - Е. Зөв бодомж байхгүй
15. Монгол Улсад шүүх эрх мэдлийг хэн хэрэгжүүлэх вэ? (2 оноо)
 - А. Улсын дээд шүүх
 - В. Нийслэлийн шүүх
 - С. Аймгуудын шүүх
 - Д. Сум, дүүргүүдийн шүүх
 - Е. Бүгд зөв
16. Аль нь илүүц вэ? Улс төрийн намын үндсэн шалгуур нь (2 оноо)
 - А. Оршин тогтнох цаг хугацаа буюу удаан хугацаагаар оршин тогтнох чадвартай байх
 - В. Засгийн эрхийн төлөө тэмцэх чадвартай байх
 - С. Удирдах төв ба орон нутгийн байгууллагатай байх
 - Д. Олон улсын улс төрийн ямар нэгэн байгууллагад нэгдсэн байх
 - Е. Тодорхой мөрийн хөтөлбөртэй байх
17. Төрийн засаглал гэсэн ойлголтод үл хамаарахыг ол. (2 оноо)
 - А. Монгол Улсын ерөнхийлөгч айл гэр, албан газар болгон морин хуурыг хоймортоо залах тухай зарлиг гаргав
 - В. УИХ-аас шинэчлэн найруулагдаж батлагдсан “Татварын багц хууль”-иуд 2007 оны I сарын 1-ээс Монгол Улс даяар мөрдөгдөж эхлэв
 - С. БСШУ-ны сайдын тушаалаар ЕБС-ийн 1 цагийг 40 минутаар тооцох болов
 - Д. Ардчилсан намын дарга Ц. Элбэгдорж намынхаа бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт хийв
 - Е. Төрийн албан хаагчдын цалинг Засгийн газрын ... дугаар тогтоолоор 20% нэмэв
18. Марксизмын үүднээс улс төр хэмээх ойлголтыг хэрхэн тодорхойлдог бэ? (2 оноо)
 - А. Улс төр нь засгийн эрх мэдлийг ашиглан нийгмийн дотор үнэт зүйлсийг хуваарилан байршуулах үйл ажиллагаа мөн
 - В. Улс төр нь эрх мэдэлд хүрэх эрх мэдлийг тогтоон барьж байх болон ашиг хонжоо олохын тулд эрх мэдлийг ашиглах албадлагын арга хэрэгслийн цогц юм
 - С. Улс төр нь эрх мэдэлд оролцох түүнийг хуваарилахад нөлөөлөхийн төлөө эрмэлзэн тэмцэх явдал юм
 - Д. Улс төр бол өөрсдийн нийгэм эдийн засгийн өвөрмөц ашиг сонирхол болон зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дэлхийн систем ба улс гүрэн, анги, түүний намаас явуулж байгаа тэмцэл, зөрчил нэвт шингэсэн нийгмийн амьдралын нэг хүрээ юм
 - Е. Улс төр бол эрх мэдэл юм
19. “Ардчилал бол засаглалын хамгийн муу хэлбэр гэвч хүн төрөлхтөн түүнээс илүү сайныг хараахан олоогүй байгаа” гэж хэн хэлсэн бэ? (2 оноо)
 - А. Т.Жефферсон
 - В. А.Линкольн
 - С. Ж.Тойнби
 - Д. У.Черчилль
 - Е. Аль нь ч биш

20. Нийгэм дэх улс төрийн харилцаа засаглалыг хэрэгжүүлэх, арга, хэлбэр, төр нийгмийн хооронд тогтсон харилцаа нийгэм дэх голлох үзэл санаа, улс төрийн соёлын түвшин зэргийн цогцыг улс төрийн шинжлэх ухаанд ... гэж үздэг. Зөв хариултыг ол. (2 оноо)
- A. Улс төрийн шийдвэр B. Улс төрийн бодлого
C. Улс төрийн дэглэм D. Улс төрийн ухамсар
E. Улс төрийн соёл
21. “Чи Монгол Улсын иргэн учраас цэргийн алба хааж, эх орныхоо төлөө хүчин зүтгэх ёстой” гэсэн нь Булдинг нарын эрдэмтдийн авч үзсэнээр эрх мэдлийг хэрэгжүүлэх хэлбэрүүдийн алинд нь хамаарах вэ? (2 оноо)
- A. Хүч хэрэглэх B. Наймаалцах
C. Үүрэг үүсгэх D. Бүгд зөв
E. Бүгд буруу
22. СХД-ийн засаг дарга тухайн дүүрэгт оршдог ерөнхий боловсролын сургуулиуд болон их дээд сургуулиудын төгсөлтийн баяртай холбоотой нэгэн шийдвэр гаргав. Засаг дарга эрх зүйн ямар акт гаргах вэ? (2 оноо)
- A. Тогтоол B. Тушаал
C. Зарлиг D. Захирамж
E. Бүгд
23. Адам Смитын “Үл үзэгдэх гар” гэдэг нь юуны тухай ойлголт вэ? (2 оноо)
- A. Өрсөлдөөн B. Монополь
C. Эрэлт D. Нийлүүлэлт
E. Зах зээл
24. Аль нь эрэлтийн хуулийг илэрхийлж байна вэ? (2 оноо)
- A. Хүмүүсийн орлого цалин нэмэгдэхийн хирээр худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ нэмэгддэг
B. Хүнсний ногоо хураах үед ногооны үнэ буурсан байдаг
C. Дэлгүүрүүдэд барааны хямдрал зарлахад худалдан авагчдын тоо нэмэгддэг
D. Чанаргүй барааны үнэ буурсан ч худалдан авагч түүнийг худалдан авдаггүй
E. Эдгээрээс өөр
25. Ижил төрлийн, орц адил хоол зоогийн газарт 1500г байхад танай сургуулийн гуанзанд 1000г байв. Энэ хамаарал юугаар илэрхийлэгдэх вэ? (2 оноо)
- A. Эрэлтийн муруй B. Нийлүүлэлтийн муруй
C. Чанар D. Зоогийн газар тул 1500г
E. Эдгээрээс өөр
26. Телевизийн “Тэнгисийн цаг” нэвтрүүлгээр хоол хийх арга технологийн талаар заадаг. Тэгвэл Тэнгис энэ ажлаа ном болгон хэвлүүлбэл монополийн тухай жишээнд орох уу? (2 оноо)
- A. Онцгой нөөцийг эзэмших
B. Хоол хийх арга технологи тул монополь биш
C. Оюуны хөдөлмөр тул монополь биш
D. Булчингийн хөдөлмөр тул монополь биш
E. Хуулиар зөвшөөрөгдсөн зүй ёсны монополь
27. Сурагч Бат өвлийн амралтаараа олимпиадад бэлтгэх мөн чөлөөт цагаараа ажил хийх зорилготой байлаа. Эдгээр ажлыг зэрэг хийх боломжгүй тул олимпиадад бэлтгэхэд амралтаа зориулав. Батын алдагдсан боломжийн өртгийг тодорхойл. (2 оноо)
- A. Алдагдсан боломжийн өртөг байхгүй. Учир нь тэр мөнгө зарцуулаагүй
B. Хичээлийн олимпиадад бэлтгэх
C. Ажиллах
D. Гэртээ байх
E. Эдгээрээс өөр
28. Үндэсний орлогыг тодорхойлно уу. (2 оноо)
- A. Үндэсний нийт бүтээгдэхүүний хэмжээнээс элэгдлийн шимтгэлийг хасах
B. Үндэсний нийт бүтээгдэхүүний хэмжээнээс шууд бус татварыг хасах
C. Үндэсний цэвэр бүтээгдэхүүний хэмжээнээс элэгдлийн шимтгэлийг хасах
D. Үндэсний цэвэр бүтээгдэхүүний хэмжээнээс шууд бус татварыг хасах
E. Үндэсний нийт бүтээгдэхүүнээс дотоодын нийт бүтээгдэхүүнийг хасах
29. Хувьцаа бонд хоёрын ялгааг ол. (2 оноо)
- A. Зөвхөн нэг удаа л борлогддог B. Ямар ч эрсдэлгүй
C. Илүү үнэ цэнэтэй D. Корпорацийн авсан зээл
E. Эдгээрээс өөр

30. 10000г-ийн өртөг нь юу вэ? (2 оноо)
 А. Хэвлэгдсэн тусгай цаасны өртөг
 В. Алтан баталгааны өртөг
 С. Хэвлэхэд зарцуулсан хөдөлмөрийн өртөг
 D. 10000 төгрөгөөр авч болох бараа үйлчилгээний өртөг
 E. Эдгээрээс өөр
31. Германы машины нэгэн үйлдвэрийн томоохон компанид үйлдвэрлэсэн машины борлуулалт багассанаас, мөн үйлдвэрлэлийн дамжлагыг өөрчилснөөс 3000 ажилчин ажлын байраа орхих тооцоо гарчээ. Энэ нь ажилгүйдлийн ямар хэлбэрт багтах вэ? (2 оноо)
 А. Зөрүү (завсрын) ажилгүйдэл
 В. Бүтцийн (байнгын) ажилгүйдэл
 С. Мөчлөгийн (циклийн) ажилгүйдэл
 D. А ба В зөв
 E. Аль нь ч биш
32. Мөнгө ямар нөхцөлөөс болж үүссэн бэ? (2 оноо)
 А. Барааг мөнгөөр солиход
 В. Мөнгөний ханш тогтооход
 С. Барааг хэмжиж тоолоход
 D. Бараа солилцооны ханш тогтооход
 E. Барааг бараагаар солилцох үед
33. Мөнгө угаах гэмт хэрэг гэж юу? (2 оноо)
 А. Хар тамхи, зэвсгийн наймаа хийх
 В. Дээрэм хийх
 С. Хулгай тонуул хийх
 D. Хүний наймаа
 E. Хууль бус аргаар бүрдүүлсэн мөнгийг хуулиар зөвшөөрсөн эх үүсвэрээс олсон болгож хувиргах үйл ажиллагаа
34. Цалин хөлс өрхийн орлогын ихэнхийг бүрдүүлдэг. Хүний хөдөлмөрийг ашигласны төлөө түүний тоо чанарт нийцүүлэн төлөх мөнгөн төлбөрийг цалин хөлс гэнэ. Тэгвэл ямар цалингийн хэмжээ орлогын ерөнхий түвшинг харуулах боловч хүний амжиргааны түвшинг харуулдаггүй вэ? (2 оноо)
 А. Бодит цалин
 В. Цагаар олгох
 С. Нэрлэсэн цалин
 D. Хийснээр олгох цалин
 E. Эдгээрээс өөр
35. Хувийн орлого гэж юу вэ? (2 оноо)
 А. Жилийн турших өрхийн орлого
 В. Хувийн хадгаламжийн хэмжээ
 С. Жилийн турших үйлдвэрийн бүтээгдэхүүн
 D. Татвар төлсний дараах хувийн зорилгод зориулагдсан нийт орлого
 E. Аль нь ч биш
36. Далд эдийн засгийн онцлог шинжид хамааралгүйг ол. (2 оноо)
 А. Хууль бус орлого нь хөдөлмөртэй холбоогүй, бусдын хөдөлмөрийг завшсан байдаг
 В. Хээл хахууль өгөх замаар аж ахуйн болон төр, эрх зүйн аппаратын дэмжлэгийг ямагт авч байдаг
 С. Зохион байгуулалттай бүлэг гэмт хэрэг үүсэн бий болох нөхцөлийг бүрдүүлж байдаг
 D. Албан ёсны эдийн засгийг сульдаан доройтуулж, шимэгч нь болж байдаг
 E. Зүй ёсны давхар ажил эрхлэлт явагддаг
37. АНУ-д байгаа давхраажилтыг дурьдахдаа илүүц нь аль нь вэ? (2 оноо)
 А. Дээд давхраа
 В. Дунд давхраа
 С. Доод давхраа
 D. Ажилчин
 E. Гуйлгачин
38. Монголын түүхэнд 1921-1990 оны үеийг социализмын үе гэж нэрлэдэг. Социализмын үед нийгмийн тэгш бус байдлыг арилгахыг эрмэлзэж байсан билээ. Тэгвэл энэ үед тэгш байдлыг тогтоохын тулд хамгийн гол нь юуг устгахыг зорьж байсан бэ? (2 оноо)
 А. Орлогын зөрөөг
 В. Арьс өнгөний ялгааг
 С. Хувийн өмчийг
 D. Нийгмийн өмчийг
 E. Боловсролын ялгааг
39. Эртний Энэтхэгийн домогт гардгаар кастын системийн нэгэн шат болох бярман нар Прушу бурхны ямар эрхтнээс үүссэн гэж үздэг бэ? (2 оноо)
 А. Гарнаас
 В. Амнаас
 С. Гуянаас
 D. Уушигнаас
 E. Зүрхнээс
40. Германы философич К.Маркс анги бол давхраажилтын хэмжигдхүүн гэж үздэг. Марксизмд ангигүй нийгмийн тухай үзэл гол байр суурь эзэлдэг билээ. Тэгвэл, марксизмын үүднээс аль нь ангигүй нийгмийн хэлбэр вэ? (2 оноо)

- А. Феодалын нийгэм
С. Боолт нийгэм
Е. Зөв хариулт байхгүй
- В. Капиталист нийгэм
D. Хүй нэгдлийн нийгэм
41. Нийгмийн бүтцийн өөрчлөлттэй холбогдон нийгмийн тодорхой бүлгийн гишүүдийн статуст өөрчлөлт гарах нь аль хэлбэрийн шилжих хөдөлгөөн бэ? (2 оноо)
А. Хувийн
С. Босоо
Е. Үе хоорондын
В. Бүлгийн
D. Хэвтээ
42. Зан заншил юмуу хуулиудаар баталгаажсан угсаа залгамжилдаг нийгмийн давхараажилтын хэв маяг аль нь вэ? (2 оноо)
А. Каст
С. Язгуур
Е. Аль нь ч биш
В. Боолчлол
D. Анги
43. Тодорхой бие хүний амьдрал, үйл ажиллагааны явцад түүний статуст өөрчлөлт гарах нь ямар хэлбэрийн шилжих хөдөлгөөн бэ? (2 оноо)
А. Хувийн
С. Босоо
Е. Нийтийн
В. Бүлгийн
D. Хэвтээ
44. Нийгмийн халамжийн төрлүүдийг зөв харгалзуул. (3 оноо)
1. Нийгмийн халамжийн үйлчилгээ
2. Нийгмийн асрамжийн үйлчилгээ
3. Нийгмийн халамж
4. Нийгмийн даатгал
а. Төрийн зүгээс зайлшгүй туслалцаа шаардлагатай нийгмийн эмзэг бүлгийг төр ивээлдээ авч буй арга хэмжээ
б. Иргэн болон төр, аж ахуйн байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлөх нийгэм, эдийн засгийн арга хэмжээ
с. Төрөөс байнга асрамжлах үйлчилгээ
d. Иргэнийг түр хугацаагаар хооллох, эсвэл түүнд наад захын хувцас, хүнс, соёлын зарим зүйл олгох, хөнгөлөлт үзүүлэх, мэргэжил эзэмшүүлэх зэрэг төрөөс үзүүлэх үйлчилгээ
- А. 1d 2a 3b 4c
D. 1b 2d 3a 4c
В. 1d 2c 3a 4b
E. 1d 2c 3b 4a
C. 1a 2c 3b 4d
45. Эртний Ромд ардчилал өндөр хөгжиж байжээ. Тэгвэл Ром гүрний нийгмийн давхраажилтын байдал ямар нийгмийн шинжийг илэрхийлдэг вэ? (2 оноо)
А. Нээлттэй нийгэм
С. Хаалттай нийгэм
Е. Зөв хариулт байхгүй
В. Өнөөгийн ардчилсан нийгэм
D. Кастын нийгэм
46. Соёл гэдэг ухагдахуун анхандаа ямар утгыг илэрхийлж байв? (2 оноо)
А. Үйлдвэрлэлийн технологи боловсруулах
С. Хөрс боловсруулах, газар тариалан эрхлэх
Е. Эдгээрээс өөр
В. Сургалтын үйл явц
D. Оюун ухааны үйл ажиллагаа
47. Доорх өгөгдлөөс буруу утгыг ол. (2 оноо)
А. Соёл хүнд удамшин дамждаг
С. Соёлыг өнөө үед сэргээн амьдруулдаг
Е. Буруу утга байхгүй
В. Соёл хүнд удамшин дамждаггүй
D. Соёлыг дараагийн үедээ дамжуулдаг
48. Соёлын гадаад талыг илэрхийлдэг соёлын үндсэн элемент аль нь вэ? (2 оноо)
А. Хэм хэмжээ
С. Үнэт зүйл
Е. Эдгээрээс өөр
В. Бэлгэ тэмдэг
D. Хэл
49. Дараах өгөгдлүүдээс аль нь соёлын хэлбэр вэ? (3 оноо)
А. Хүй нэгдлийн үеийн хүмүүс багаж зэвсэг болгон хэрэглэж байсан байгаль дээр элбэг тохиолддог хурц үзүүртэй мод чулуу
В. Гар аргаар хийгдсэн хутга, сүх, сэлэм
С. Үйлдвэрийн аргаар хийгдсэн хутга, заазуур
D. Бүгд зөв
Е. В ба С зөв

50. Аль бодомж нь зөв бэ? (2 оноо)
- Соёл бол байгаль, нийгмийн үзэгдэл
 - Соёл бол байгальд илрэх байдлын эсрэг үзэгдэл
 - Соёл бол нийгмийн тогтонги ба өөрчлөмтгий шинжтэй үзэгдэл
 - Соёл бол нийгэмд хааяа тохиолдох ховор үзэгдэл
 - Бүгд буруу
51. Хүний туршлагыг хадгалж, дамжуулах, бодит хэлбэр болох соёлын үндсэн элемент аль нь вэ?
- Хэм хэмжээ
 - Бэлгэ тэмдэг
 - Үнэт зүйл
 - Хэл
 - Эдгээрээс өөр
52. Төсөөлөл, үнэт зүйл, мэдлэг, үзэл суртал, хэл яриа, оюуны үйлдвэрлэл ямар соёлд багтах вэ?
- Материаллаг соёл
 - Материаллаг бус соёл
 - Нийтийн соёл
 - А ба С зөв
 - Эдгээрээс өөр
53. Дараах өгөгдлийг зөв харгалзуул. (3 оноо)
- Идэвхтэй гадаад бодлого
 - Дэлхийн улс гүрнүүдтэй аль болох хамтын ажиллагаагаа өргөжүүлэх тэдний ашиг сонирхлыг монголд бүрдүүлэхэд чиглэсэн бодлого
 - Үндэсний эрх ашигт нийцсэн
 - Бодлогын хүрээ, бодлогын зорилтыг томъёолсон, гадаад бодлого зорилгодоо хүрэх стратегийг боловсруулсан, түүнийг хэрэгжүүлэх механизмыг тодорхойлсон
 - Тэнцвэртэй гадаад бодлого
 - Стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн монгол дахь эдийн засгийн болон бусад сонирхлыг нэг түвшинд барихад чиглэсэн бодлого
 - Олон тулгуурт бодлого
 - Тусгаар тогтнолыг сахин хамгаалах эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого
- 1a 2c 3b 4d
 - 1b 2d 3a 4c
 - 1d 2a 3c 4b
 - 1d 2c 3a 4b
 - 1b 2d 3c 4a
54. Хэдээс дээш улс оролцож байгуулсан хамтын байгууллагыг олон улсын байгууллага гэх вэ?
- 2
 - 3
 - 4
 - 5
 - 6
55. Олон улсын харилцаанд өөрийгөө төлөөлөх тодорхой байгууллагаар дамжуулан харилцаж болдог, нилээд хязгаарлагдмал субъект аль нь вэ?
- Олон улсын байгууллага
 - Ард түмэн
 - Төр засаг
 - Үндэстэн дамнасан байгууллага
 - А ба В зөв
56. Монгол Улс 2004 онд 1-рт Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад, 2-рт Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээнд элсэн орсон. Зөв өгөгдлийг ол. (2 оноо)
1. ажиглагчаар; 2. гишүүнээр
 - 1, 2 ажиглагчаар
 - 1, 2 гишүүнээр
 1. гишүүнээр; 2. ажиглагчаар
 - Аль алинд нь элсээгүй
57. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 56-р чуулганд Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаяр ямар утгатай үг хэлсэн бэ?
- Терроризмтай хийх тэмцэлд оролцохоо илэрхийлсэн
 - Терроризмын олон талт үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулахад оролцох боломжтой
 - Терроризмтай тэмцэх Олон улсын хамтын нийгэмлэгийн хүч чармайлтыг тууштай дэмжихээ илэрхийлсэн
 - Терроризмтай тэмцэхэд хүн хүчний тусламж үзүүлнэ
 - Терроризмтай тэмцэхэд санхүү, эдийн засгийн дэмжлэг үзүүлнэ
58. 1945 оны Х сарын 23-ны өдөр НҮБ гэсэн нэртэй олон улсын шинж чанартай байгууллага байгуулагдаж дүрмээ баталсан байна. Энэ үйл явдал аль улсын аль хотод болсон бэ? (2 оноо)
- ЗХУ-ын Москва
 - АНУ-ын Сан Франциско
 - АНУ-ын Нью-Йорк
 - Английн Лондон
 - Швейцарын Женев

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Дараах үйлдвэрлэлийн зардлуудыг 2.1-д зөв харгалзуул. (А, В, С, D, E тус бүрд харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу). (5 оноо)

А. Гадаад зардал

В. Дотоод зардал

С. Тогтмол зардал

D. Хувьсах зардал

E. Үйлдвэрлэлийн нийт зардал

1. Тогтмол ба хувьсах зардлын нийлбэр

2. Үйлдвэрлэлийн хэмжээний өөрчлөлтөөс хамааран тоо нь өөрчлөгдөх зардал

3. Хөдөлмөр, материал, түлш, тээврийн үйлчилгээ зэргийг худалдан авахад төлж буй төлбөр

4. Үйлдвэрлэлд ашиглаж буй тухайн үйлдвэрлэгчийн өөрийн хөрөнгө нөөц

5. Үйлдвэрлэлийн бүтээгдхүүний өөрчлөлтөөс үл хамааран тогтвортой байдаг зардал

2.2. Орчин үеийн АНУ-ын нийгэм дэх ангиудыг 2.2-д зөв харгалзуул. (А, В, С, D, E тус бүрд харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу). (5 оноо)

А. Ажилчин анги

В. Доод

С. Дээд дунд

D. Дээд ангийн доод

E. Доод дунд

1. Жижиг бизнес эрхлэгчид, фермерүүд, худалдаачид, багш, сувилагч, санваартан, корпораци болон орон нутгийн захиргааны албан хаагчид буюу “Цагаан цамцтан” гэж нэрлэгддэг хүмүүс

2. Дунд сургуулийн юм уу худалдааны сургууль, дагалдангаас өөр албан боловсролгүй, “Хөх цамцтан” гэж нэрлэгддэг хүмүүс

3. Асар их мөнгө, баялагтай боловч удам угсаа нэр хүндийг олоогүй хүмүүс

4. Их дээд сургуулийн боловсролтой, нэр хүнд өндөр, хангалуун амьдралтай, корпораци болон засгийн газрын дунд ба өндөр түвшний мэргэжилтэн

5. Удаан хугацаагаар ядуу амьдрагсад, мэргэжилгүй ажилчид, доодос гэсэн хоёр янз. бодлого

ХУВИЛБАР E

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. “Нийгэм бол хувьслын замаар хөгждөг ахуй мөн” гэж хэлсэн бэ? (2 оноо)

А. Г.Спенсер

С. Н.Макиавелли

E. М.Вебер

В. О.Конт

D. Э.Дюркгейм

2. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. ... институт нь нийгмийн амгалан тайван байдал, аюулгүй байдал, бүх нийтийн эрх ашгийг хамгаалах хангахад чиглэгддэг. (2 оноо)

А. Улс төр

С. Боловсрол

E. Бусад

В. Шашин

D. Гэр бүл

3. Нийгмийн харилцан үйлчлэлийг өгөгдлөөс олно уу. (2 оноо)

А. Нийгмийн системийг бүрэлдүүлэгч хүчин зүйлс

В. Хүмүүс бие биедээ нөлөөлж, үйлчилж байдаг үйл явц

С. Хамтын үйл ажиллагааг нөхцөлдүүлэгч хүчин зүйлс

D. Объектив шинжтэй

E. Эдгээрээс өөр

4. Аль нь олдмол статус вэ? (2 оноо)

А. Миний аавыг Доржийн Дамдин гэдэг

В. Би 18 настай Миний нэрийг Заяа гэдэг

С. Эмэг ээж маань удмын уртын дуучин

D. Манайх удахгүй хотод шилжин суурьшина

E. Аль нь биш

5. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. Г.Зиммель, хөгжлийн явцад хүмүүс хоорондоо хүссэн хүсээгүй ялгаралд орж байдаг. Жижиг бүлэгт бие бялдраараа ялгарч байдаг бол, томоохон орчинд ... ялгардаг. (2 оноо)

А. Эд баялгаар	В. Эрх мэдлээр
С. Оюун ухаанаар	Д. Боловсролоор
Е. Бусад зүйлээр	
6. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол “... гэдэг нь нийгэм ба соёлоос хожуу үүссэн ч дэлхийчлэлийн цар хүрээний ач холбогдолтой, нийгэм ба нийгэмлэгүүдийн соёлын хөгжлийн шат түвшин болон тэдгээрийн өвөрмөц шинжийг тусгасан ойлголт” юм. (2 оноо)

А. Даяаршил	В. Нийгэмшил
С. Иргэншил	Д. Уламжлал
Е. Эдгээрээс өөр	
7. Аж үйлдвэржсэн нийгмийн үйлдвэрлэлд юу давамгайлдаг вэ?

А. Хөдөө аж ахуй	В. Аж үйлдвэр
С. Үйлчилгээний хүрээ	Д. Мэдээллийн технологи
Е. Эдгээрээс өөр	
8. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. ... институт нь нийгмийн хүн амын нөхөн үйлдвэрлэлийг хангаж хойч үеийг өсгөн хүмүүжүүлэх функцыг хэрэгжүүлдэг. (2 оноо)

А. Улс төр	В. Эдийн засаг
С. Боловсрол	Д. Гэр бүл
Е. Хамт олон	
9. Нийгмийн институтуудыг гэр бүл ба боловсрол, эдийн засаг, улс төр, төр, эрх зүйн соёлын гэх мэтээр тодорхойлдог ямар шинжлэх ухаан байдаг вэ? (2 оноо)

А. Социологи	В. Нийгэм
С. Байгаль	Д. Түүх
Е. Эдгээрээс өөр	
10. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд гэр бүлийг тодорхойлохдоо “Гэр бүл гэж гэрлэлтийн үр дүнд бий болсон, эд хөрөнгийн бус, амины болон эд хөрөнгийн эрх үүргээр холбогдсон ... хэлнэ”. (2 оноо)

А. Хамтын амьдрал бүхий гэр бүлийн хүмүүсийг
В. Хамтын амьдрал бүхий гэр бүл, гишүүдийг
С. Хамтын амьдрал бүхий эхнэр, нөхрийг
Д. Хамтын амьдрал бүхий нөхөр, эхнэр, үр хүүхдийг
Е. Аль нь ч биш
11. Монгол Улсын Үндсэн хууль дахь заалт аль нь вэ? (2 оноо)

А. Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ
В. Монгол Улсад төр нь шашнаа дээдэлж, шашин нь төрөө хүндэтгэнэ
С. Монгол Улсад төр нь шашнаа, шашин нь төрөө дээдэлж, хүндэтгэнэ
Д. Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө хүндэтгэнэ
Е. Аль нь ч биш
12. Улс төрийн мэдрэмж, ойлголт, уламжлал, үнэлэлт, дүгнэлт, үзэл санаа, улс төрийн ашиг сонирхол, итгэл үнэмшил, улс төрийн мэдлэг, онол зэргийн нийлбэр цогцыг улс төрийн шинжлэх ухаанд ... гэж үздэг. Зөв хариултыг ол. (2 оноо)

А. Улс төрийн шийдвэр	В. Улс төрийн бодлого
С. Улс төрийн дэглэм	Д. Улс төрийн ухамсар
Е. Улс төрийн үйл ажиллагаа	
13. Төсвийн байгууллагын ажилтнууд цалингаа нэмэгдүүлэх талаар Засгийн газарт хандаж шаардлага тавьжээ. Засгийн газраас тэдний цалинг тодорхой хувиар нэмжээ. Гэсэн ч тэд сэтгэл дундуур байгаа бөгөөд хэсэг хугацааны дараа дахин шаардлага тавих төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газраас явуулж буй бодлого, үйл ажиллагаанд сэтгэл дундуур байна. Дээрх өгөгдөлд аль нь хамаарах вэ? (2 оноо)

А. Оролт	В. Гаралт
С. Дэмжлэг	Д. Шаардлага
Е. Эргэх холбоо	
14. Намын дотоод үүргийг дурьдахдаа гадаад үүргээс оруулсан бол аль нь вэ? (2 оноо)

А. Дэмжигчдээ улс төрийн талаар гэгээрүүлэх замаар гишүүн элсүүлэх
В. Төв байгууллага нь анхан шатны байгууллагатайгаа холбоотой ажиллаж, баримт бичиг, материалаар хангах

- С. Улс төрийн лидерүүдийг бий болгох
D. Улс төрийн боловсон хүчнийг шилж сонгох
E. Засгийн эрхийн төлөө тэмцэх
15. Г.Лассуэл “Улс төр” хэмээх ойлголтыг хэрхэн тодорхойлсон бэ? (2 оноо)
A. Улс төр нь засгийн эрх мэдлийг ашиглан нийгмийн доторх үнэт зүйлийг хуваарилан байршуулах үйл ажиллагаа
B. Улс төр нь эрх мэдэлд хүрэх, түүнийг тогтоон барих болон ашиг хонжоо олохын тулд эрх мэдлийг ашиглах албадлагын арга хэрэгслийн цогц юм
C. Улс төр нь эрх мэдэлд оролцох түүнийг хуваарилахад нөлөөлөхийн төлөө эрмэлзэн тэмцэх явдал юм
D. Улс төр бол эрх мэдэл юм
E. Улс төр бол хэн, юуг, хэзээ, хэрхэн олж, авч буй тэмцэл юм
16. Аль нь зөв бэ? Аливаа улс төрийн намын туйлын зорилго нь: (2 оноо)
A. Засгийн эрхийг гартаа авах
B. Гишүүн элсүүлэх
C. Үзэл баримтлал ижил гадаадын улс төрийн намуудтай хамтран ажиллах
D. Нам дэмжигчдээ улс төрийн талаар гэгээрүүлэх
E. Түүх, соёлын үнэт зүйлсүүдийг хамгаалах
17. Оновчтойг сонго. Улс орны бүхий л хүрээг хамарсан улс төрийн бодлого боловсруулах, улс төрийн тогтолцоог бүрдүүлэхэд оролцох нь (2 оноо)
A. Сонирхлын бүлгийн үүрэг
B. Тухайн байгууллагын үүрэг
C. Хандивлагч орны үүрэг
D. Улс төрийн намын үүрэг
E. Зөв хариулт байхгүй
18. Төлөөллийн ардчиллын давуу талуудыг дурьдахдаа илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ? (3 оноо)
A. Нийгэмд улс төрийн тогтвортой байдал, дэг журмыг илүү хангадаг
B. Улс төрийн тогтолцоог илүү мэргэшиж, туршлагажсан хүмүүс удирдан зохион байгуулдаг
C. Улс төрийн хариуцлагыг өндөржүүлдэг
D. Хүн амын янз бүрийн давхрааны хэт ялгарал эсвэл тэгшитгэх байдлаас нийгмийг хамгаалах
E. Төлөөлөгчид нь ихээхэн эрх мэдэлтэй ба удаан хугацаагаар сонгогддог
19. Хүн амыг бүхэлд нь юм уу эсвэл нийгмийн нэг тодорхой хэсгийг төлөөлсөн бүлэг хүмүүс ба байгууллагын төрийн засаглалд нөлөөлөх оролцох идэвхтэй үйлдлийг улс төрийн шинжлэх ухаанд юу гэх вэ? (2 оноо)
A. Улс төрийн шийдвэр
B. Улс төрийн дэглэм
C. Улс төрийн соёл
D. Улс төрийн үйл ажиллагаа
E. Улс төрийн бодлого
20. “Та цэргийн алба хаах ёстой тэгэхгүй бол ...” гэсэн нь Булдинг нарын эрдэмтэдийн авч үзсэнээр эрх мэдлийг хэрэгжүүлэх хэлбэрүүдийн алинд хамаарах вэ? (2 оноо)
A. Хүч хэрэглэх
B. Наймаалцах
C. Үүрэг үүсгэх
D. Бүгд зөв
E. Бүгд буруу
21. Монгол Улсад шүүх эрх мэдлийг хэн хэрэгжүүлэх вэ? (2 оноо)
A. Улсын дээд шүүх
B. Нийслэлийн шүүх
C. Аймгуудын шүүх
D. Сум, дүүргүүдийн шүүх
E. Бүгд зөв
22. СХД-ийн засаг дарга тухайн дүүрэгт оршдог ерөнхий боловсролын сургуулиуд болон их дээд сургуулиудын төгсөлтийн баяртай холбоотой нэгэн шийдвэр гаргав. Засаг дарга эрх зүйн ямар акт гаргах вэ? (2 оноо)
A. Тогтоол
B. Тушаал
C. Зарлиг
D. Захирамж
E. Бүгд
23. Эдийн засгийн шинжлэх ухааны гол үүргийг тодорхойл. (2 оноо)
A. Эдийн засгийн үйл ажиллагааг зохицуулах
B. Эдийн засгийн үйл ажиллагааг зохион байгуулах
C. Эдийн засгийн үйл ажиллагааг шийдвэрлэх
D. Эдийн засгийн үйл ажиллагааны талаар таамаглал дэвшүүлэх
E. Эдгээрээс өөр
24. Эдийн засгийн бодит хууль зүй тогтлыг таньж мэдэхэд аль нь тохирохгүй вэ? (2 оноо)
A. График
B. Анализ ба синтез
C. Загварчлал
D. Программчилал
E. Эдгээрээс өөр

34. Хувийн орлого гэж юу вэ?
A. Жилийн турших өрхийн орлого
B. Хувийн хадгаламжийн хэмжээ
C. Жилийн турших үйлдвэрийн бүтээгдэхүүн
D. Татвар төлсний дараах хувийн зорилгод зориулагдсан нийт орлого
E. Аль нь ч биш
35. Германы машины нэгэн үйлдвэрийн томоохон компанид үйлдвэрлэсэн машины борлуулалт багассанаас, мөн үйлдвэрлэлийн дамжлагыг өөрчилснөөс 3000 ажилчин ажлын байраа орхих тооцоо гарчээ. Энэ нь ажилгүйдлийн ямар хэлбэрт багтах вэ? (2 оноо)
A. Зөрүү (завсрын) ажилгүйдэл
B. Бүтцийн (байнгын) ажилгүйдэл
C. Мөчлөгийн (циклийн) ажилгүйдэл
D. А ба В зөв
E. Аль нь ч биш
36. Ажилгүйдлын түвшин юуг илэрхийлдэг вэ? (2 оноо)
A. Ажилгүй хүмүүсийн тоог илэрхийлнэ
B. Ажиллах хүчний дотор ажилгүйчүүдийн эзлэх хувийг илэрхийлнэ
C. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил эрхэлж байгааг илэрхийлнэ
D. Ажил хийхийг хүсч идэвхтэй ажил хайж байгаа хүмүүсийг хэлнэ
E. Ажил олговч ажил хийдэггүй хүмүүс
37. Эртний Энэтхэгийн домогт гардгаар кастын системийн нэгэн шат болох Шудра нар Прушу бурхны ямар эрхтнээс үүссэн гэж үздэг вэ? (2 оноо)
A. Гарнаас
B. Хөлнөөс
C. Гуянаас
D. Уушигнаас
E. Зүрхнээс
38. Эртний Грекийн философич Аристотель өөрийн амьдарч байсан нийгмийнхээ давхрааны хамгийн доод хэсгийнхнийг “ярьдаг зэвсэг” гэж нэрлэж байжээ. Тэгвэл Аристотелийн “ярьдаг зэвсэг” гэж нэрлэсэн нийгмийн тэр хэсэг нийгмийн давхраажилтын аль хэв маягийг илэрхийлж байна вэ? (2 оноо)
A. Анги
B. Каст
C. Язгуур
D. Боолчлол
E. Аль нь ч биш
39. Иргэний эрхтэй эсэхээрээ ялгаатай нэг нь нөгөөгийнхөө өмч нь болдог давхраажилтын хэв маяг аль нь вэ? (2 оноо)
A. Каст
B. Боолчлол
C. Язгуур угсаа
D. Анги
E. Аль нь ч биш
40. Эртний Грекийн Афин хотод ардчилал өндөр хөгжиж байжээ. Тэгвэл Афин хотын нийгмийн давхраажилтын байдал ямар нийгмийн шинжийг илэрхийлдэг вэ? (2 оноо)
A. Нээлттэй нийгэм
B. Өнөөгийн ардчилсан нийгэм
C. Хаалттай нийгэм
D. Кастын нийгэм
E. Зөв хариулт байхгүй
41. Өгөгдлийг зөв харгалзуул. (2 оноо)
1. Ядуус a. Амьдралын наад захын хэрэгцээгээ хангах чадваргүй байдал
2. Нэн ядуу b. Төрөөс тогтоосон амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэд
3. Үнэмлэхүй ядуурал c. Өрхийн нэг хүнд оногдох орлого нь амжиргааны доод түвшний 40%-д хүрэхгүй байх
4. Харьцангуй ядуурал d. Амьдралын боломжийн жишиг гэж тухайн нийгмийн үзэж байгаа зүйлсийг хангах чадваргүй байдал
A. 1b 2c 3a 4d B. 1c 2a 3d 4b C. 1b 2a 3c 4d
D. 1a 2b 3c 4d E. 1d 2a 3c 4b
42. Судлаач Х.Гүндсамбуу социализмын үеийн Монголын нийгмийн давхраажилтыг 4 ангилан авч үзжээ. Үл хамаарахыг ол? (2 оноо)
A. Хоршоолсон ард
B. Ажилчин
C. Сэхээтэн
D. Номенклатур (Дарга анги)
E. Хөрөнгөтний
43. Нийгмийн шилжих хөдөлгөөнд үеийн доторх ба үе хоорондын хөдөлгөөн гэсэн хэлбэр байдаг. Дараах өгөгдлөөс үе хоорондын хөдөлгөөний жишээ аль нь вэ? (2 оноо)
A. Иргэн Болд Архангай аймгийн Цэцэрлэг сумаас мөн аймгийн Хашаат сум руу шилжжээ
B. Багш Дорж 7 жилийн дотор дадлагажигч багшаас профессор багш болтлоо өссөн байна
C. Багш Сүрэн 87-р сургуулиас 56-р сургууль руу шилжсэн
D. Захирал Бадамсүрэн ОХУ-руу ажлаар явсан байна
E. УИХ-ын гишүүн Г.Батхүүгийн аав жолооч байсан

44. Эцэг эх, гэр бүлээс залгамжилсан статусаа тодорхой бие хүн, өөрчлөх нь аль хэлбэрийн шилжих хөдөлгөөн бэ? (2 оноо)
- A. Босоо чиглэлт B. Хэвтээ чиглэлт
C. Үе хоорондын D. Үе доторх
E. Хувийн
45. Аль онол соёл бол нийгмийн нягтралыг хангаж байдаг гэж үздэг вэ? (2 оноо)
- A. Бүтэц үүргийн онол B. Угсаатны арга зүйн онол
C. Зөрчилдөөний онол D. Уламжлалт онол
E. Марксист онол
46. Нийгэм хийгээд соёл хоорондын холбоог тодорхойл. (2 оноо)
- A. Соёл бол хүний бүтээсэн үнэт зүйл мөн
B. Соёл бол хүний бүтээсэн материаллаг зүйл мөн
C. Соёл бол утга учир бэлгэдлийн систем мөн
D. Соёл бол урлаг мөн
E. Соёл бол ухамсар мөн
47. Төрийн соёлын бодлого гэж юуг хэлэх вэ? (2 оноо)
- A. Үндэсний соёл, түүх дурсгалыг хамгаалах төрийн бодлого
B. Үндэсний соёл болон түүний бүтээгчдэд хамаарах төрийн бодлого
C. Нийтийн урлаг, уран сайхныг хөгжүүлэх төрийн бодлого
D. Үндэсний бичиг үсгийг дэлгэрүүлэн хөгжүүлэх төрийн бодлого
E. Үндэсний чанартай юм бүгдийг дээдлэх, дэлгэрүүлэх бодлого
48. 1990 оны Монголд өрнөсөн ардчилсан өөрчлөлт нь соёлын аль элементэд багтах вэ? (2 оноо)
- A. Хэм хэмжээ B. Шашин
C. Үнэт зүйл D. Хэл
E. Алинд нь ч багтахгүй
49. “Монгол хүн уурган дээгүүр алхдаггүй Монгол ёсыг улан дороо гишгэдэггүй Аав минь надад ингэж хэлсэн юм Анхааралтай би чагнаж суусан юм” энэ шүлэгт юуг илэрхийлж байна вэ? (3 оноо)
- A. Ёс суртахууны хэм хэмжээ B. Ёс заншлын хэм хэмжээ
C. Эрх зүйн буюу албан хэм хэмжээ D. Бүгд буруу
E. Бүгд зөв
50. Өнөөдөр манай нийслэлд халх, буриад, казах, дөрвөд, дархад, урианхай зэрэг олон угсаатан ястан амьдрахаас гадна европ, ази, америк тивийн олон орнуудаас хүмүүс ирж амьдарч, ажиллаж байна. Энэ нь соёлын ямар бүрэлдэхүүнийг үүсгэж байна вэ? (2 оноо)
- A. Элитийн соёл B. Дэд соёл
C. Нийтийн соёл D. Үндэсний соёл
E. Эдгээрээс өөр
51. Хүнд зайлшгүй хэрэгтэй бүгдээс илүү дээгүүр гэдгийг хүлээн зөвшөөрч, түүнд тэмүүлж ихэд хүндэтгэн дээдэлж, биширч харилцдаг хүний мэдрэмж, амьдралын үнэт чиглэлийг үнэт чанар гэдэг ажээ. Тэгвэл үнэт чанарыг судалдаг ухааныг юу гэдэг вэ? (2 оноо)
- A. Аксеологи B. Археологи
C. Түүх D. Антропологи
E. Эдгээрээс өөр
52. Өгөгдлийг зөв харгалзуул. (2 оноо)
1. Олон улсын худалдааны тэнцвэрт өсөлтийг хангах a. WHO
2. Хүмүүсийн амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, чанарыг б. IMF
дээшлүүлэх, ядуучуудын амьдралын нөхцөлийг сайжруулах c. ILO
3. Эрүүл мэндийн бүх талын тусламж, үйлчилгээг хөгжүүлэх туслах
4. Хүүхдийн хөдөлмөрийг зогсооход чиглэсэн үйл ажиллагааг авч явуулах d. World Bank
- A. 1d 2a 3b 4c B. 1d 2c 3a 4b C. 1b 2c 3d 4a
D. 1b 2d 3a 4c E. 1d 2c 3b 4a
53. Хүн төрөлхтөн соёлыг асар өргөн хүрээтэй ойлголт гэж үздэгээс харьцангуй бие даасан мэт харилцааг соёлын харилцаанд багтаан ойлгодог. Дараах салбарын аль нь соёлын харилцаанд хамаарагдахгүй вэ? (2 оноо)
- A. Олон улсын жуулчлал B. Шинжлэх ухааны салбар
C. Боловсролын салбар D. Урлагийн салбар
E. Техникийн салбар

54. Монгол Улсаас “Дэлхийн утга соёлын шилдэг өвийн дээжис”-д нэр дэвшүүлсэн урлагийн төрөлд хамрагдахгүйг ол. (2 оноо)
 А. Хөөмий В. Уртын дуу С. Морин хуур D. Тууль E. Уран нугаралт
55. “Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон Олон улсын бусад үйл ажиллагаанд оролцуулах тухай” Монгол Улсын УИХ-аар 2002 онд баталсан хуулийн хүрээнд Монгол Улсын цэрэг хаана, ямар үйл ажиллагаа явуулсан бэ? (2 оноо)
 А. Африкийн гурван оронд хэрэгжүүлж буй энхийг сахиулах үйл ажиллагаанд ажиглагчаар оролцсон
 В. Гадаад 10 гаруй оронтой хамтарсан хээрийн сургалт дадлагын ажлыг зохион байгуулсан
 С. 2006 оноос Соерра Моне Улсад 250 хүнтэй цэргийн баг илгээсэн
 D. 2003 оноос Ирак, Афганистанд энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож байна
 E. Бүгд зөв
56. Зөв харгалзуул. (2 оноо)
 1. ЮНЕСКО а. НҮБ-ын Хүүхдийн сан
 2. UNHCR б. НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар
 3. ЮНИДО с. НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан соёлын байгуулал
 4. ЮНИСЕФ d. Үйлдвэр хөгжлийн байгууллага
 А. 1a 2c 3b 4d В. 1b 2d 3a 4c C. 1d 2a 3c 4b
 D. 1d 2c 3a 4b E. 1c 2b 3d 4a
57. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Финлянд Улсын Засгийн газар хоорондын “Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай” хэлэлцээрт Үйлдвэр, худалдааны сайд Ц. Даваадорж, Финлянд Улсаас манай оронд суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Анти Коузмини нар өчигдөр албан ёсоор гарын үсэг зурлаа. Энэ хэлэлцээр нь хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх, финляндын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм. Энэ нь ямар талт харилцаанд хамаарах вэ? (2 оноо)
 А. Хоёр талт улс төрийн харилцаа В. Хоёр талт эдийн засгийн харилцаа
 С. Олон талт эдийн засгийн харилцаа D. Олон талт улс төрийн харилцаа
 E. Хоёр талт хүмүүнлигийн харилцаа
58. Дэлхийн II дайны дараа дэлхийн улс орнууд социалист, капиталист гэсэн бие биедээ дайсагнасан 2 лагерт хуваагдаж, үзэл суртал, цэрэг зэвсгийн талаар сөргөлдөн тэмцэх болсон. Доорх байгууллагуудаас аль нь социалист лагерийг төлөөлөх вэ? (2 оноо)
 А. Умард Атлантын гэрээний байгууллага В. Варшавын гэрээний орнуудын байгууллага
 С. Европын нэгдсэн холбоо D. Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо
 E. Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. Татварын ангиллуудыг 2.1-д зөв харгалзуул. (А, В, С, D, E тус бүрд харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу). (5 оноо)
 А. Прогрессив татвар 1. Хэрэглээний бараа үйлчилгээний борлуулалтаас авч буй татвар
 В. Регрессив татвар 2. Орлого өсөхийн хирээр татварын дундаж хэмжээ өсдөг татвар
 С. Пропорциональ татвар 3. Эд хөрөнгө эзэмшигч, орлого ологчоос төсөвт авч буй татвар
 D. Шууд татвар 4. Орлогын хэмжээнээс хамаарахгүйгээр татварын дундаж хэмжээ өөрчлөгддөггүй татвар
 E. Шууд бус татвар 5. Орлого өсөхийн хирээр татварын дундаж хэмжээ буурдаг
- 2.2. Сонгуулийн зарчмуудыг 2.1-д зөв харгалзуул. (А, В, С, D, E тус бүрд харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу). (5 оноо)
 А. Бүх нийтийн 1. Сонгогч хэний ч нөлөөнд автахгүй зөвхөн өөрийн ухамсартай үйл ажиллагаагаар саналаа илэрхийлэх боломж
 В. Тэгш эрхийн 2. Сонгуульд оролцох, эс оролцох нь сонгогчийн хувийн хэрэг бөгөөд хэний дарамт шахалтанд оролгүйгээр саналаа илэрхийлэх бүхий л бололцоогоор хангагдах явдал
 С. Шууд 3. Хуульд заасан хязгаарлалтаас бусад тохиолдолд тухай улсын насанд хүрэгчид бүгд сонгуульд оролцоно
 D. Чөлөөт 4. Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй бөгөөд нэг сонгогч нэг удаагийн сонгуульд нэг л удаа оролцоно
 E. Нууцаар санал гаргах 5. Сонгуулийн эцсийн дүн нь нийт иргэдийн санал хураалтаар шийдэгдэнэ

2007 оны Нийгмийн тухай мэдлэг хичээлийн даалгаврын түлхүүр

№	Нэгдүгээр хэсэг				
	Хувилбар А	Хувилбар В	Хувилбар С	Хувилбар D	Хувилбар E
1	B	A	A	B	A
2	B	C	D	B	A
3	C	B	A	C	B
4	C	C	D	C	D
5	C	A	A	D	C
6	B	C	D	A	C
7	A	B	A	A	B
8	B	B	C	B	D
9	B	A	B	B	A
10	D	C	B	C	B
11	B	D	C	B	A
12	D	E	D	D	D
13	E	E	D	D	E
14	A	A	E	D	E
15	C	A	B	E	E
16	D	C	D	D	A
17	A	A	A	D	D
18	D	D	C	D	E
19	D	A	B	D	D
20	D	D	D	C	A
21	C	D	C	C	E
22	C	A	C	D	D
23	E	D	B	A	C
24	A	E	E	A	D
25	B	D	C	A	B
26	D	A	A	E	B
27	D	C	D	C	B
28	E	C	B	D	D
29	C	C	B	B	E
30	A	B	B	D	B
31	A	C	A	B	C
32	B	E	D	D	B
33	D	D	B	E	C
34	B	A	B	C	A
35	D	D	C	A	B
36	D	C	A	E	B
37	C	C	C	E	B
38	A	C	C	C	D
39	B	D	D	B	B
40	D	B	C	D	C
41	A	E	D	B	A
42	D	B	A	C	E
43	A	A	A	A	E
44	C	B	B	B	C
45	C	C	B	C	A
46	B	C	C	C	C
47	B	D	D	A	B
48	B	C	C	B	C

№	Хувилбар А	Хувилбар В	Хувилбар С	Хувилбар D	Хувилбар E
49	B	B	A	D	B
50	B	D	A	C	B
51	E	E	C	D	A
52	E	A	B	B	D
53	A	B	D	E	A
54	A	D	D	B	E
55	D	A	C	B	E
56	D	C	E	A	E
57	D	E	B	C	B
58	E	C	D	B	B

	Хоёрдугаар хэсэг									
	Хувилбар А		Хувилбар В		Хувилбар С		Хувилбар D		Хувилбар E	
	2.1	2.2	2.1	2.2	2.1	2.2	2.1	2.2	2.1	2.2
a	4	2	3	3	2	4	3	2	2	3
b	5	3	4	4	3	5	4	5	5	4
c	1	5	1	5	5	3	5	4	4	5
d	3	1	5	2	4	1	2	3	3	2
e	2	4	2	1	1	2	1	1	1	1